7

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 03 сарын 12 өдөр Дугаар 46 Улаанбаатар хот

Удирдамж батлах тухай

Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах хөтөлбөр, Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. "Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг, эргэн дуудах тогтолцооны удирдамж"-ийг нэгдүгээр, "Хорт хавдар бүртгэх удирдамж"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Удирдамжийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт, мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төв (Л. Төмөрбаатар), Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар (Ш. Энхбат)-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар (Д. Жаргалсайхан)-т үүрэг болгосугай.

САЙД Н. ХҮРЭЛБААТАР

250293

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
3 дугаар сарын 12-ны өдрийн ...76.... тоот
тушаалын нэгдүгээр хавсралт

# УМАЙН ХҮЗҮҮ, ХӨХНИЙ ӨМӨНГИЙН ИЛРҮҮЛЭГ ЭРГЭН ДУУДАХ ТОГТОЛЦООНЫ УДИРДАМЖ

## 1. Удиртгал

Монгол Улсын хэмжээнд "Эрүүл Монгол хүн" уриан дор зохион байгуулагдсан урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх үзлэгийг эс тооцвол зохион байгуулалттайгаар хийгдсэн хорт хавдрын илрүүлэг үзлэг урьд нь зохион байгуулагдаж байгаагүй юм. Иймээс манай улсад илрүүлэг үзлэгийн мэдээллийн тогтолцоо, улмаар мэдээллийн урсгал болон илрүүлгийн маягтууд зэрэг нь харьцангуй шинэ ойлголт тул бусад орны туршлагаас судлах, манай улсын өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн болон тусгай мэргэжлийн төвийн төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийн саналыг тусгах, зөвлөх мэргэжилтнүүдтэй зөвлөж ажиллах шаардлага удирдамж боловсруулах явцад тулгарч байлаа. Эргэн дуудах тогтолцооны удирдамж нь умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлгийн хамралтыг сум, орон нутгаар нь гаргахаас гадна эмч, мэргэжилтнүүдийн оролцоо, өмөн болон хавдрын урьдал эмгэгтэй эмэгтэйчүүдийн оношилгоо эмчилгээ, цаашдын хяналт, зохицуулгын талаархи үндсэн лавлагаа баримт бичиг юм. Мөн эдгээр үйл ажиллагаанаас урган гарсан статистикийн мэдээлэл нь умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэг, цаашилбал хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах, үнэлэх, мөн бусад төрлийн хорт хавдрын илрүүлэг үзлэгийг зохион байгуулах, төлөвлөх болон үр дүнг хянахад лавлагаа болох ач холбогдолтой бодлогын баримт бичиг байх болно. 2011 онд батлагдаж гарсан "Умайн хүзүү, Хөхний өмөнгийн урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, тохиолдлын зохицуулалт, хяналт ба хөнгөвчлөх эмчилгээ" Монгол улсын Эмнэл зүйн удирдамжийг суурь баримт болгон энэхүү удирдамжид ашигласан болно. Мөн энэ удирдамжийн хүрээнд умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгийн мэдээлэх үйл ажиллагааны алхам тус бүрт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн оролцоог тусган зааварласан юм. Үүнд:

- Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгийг хийх давтамж
- Сонгосон эмэгтэйд урилгыг хэн, ямар аргаар хүргэх
- Үзлэг, шинжилгээний дүгнэлтийг хэрхэн мэдээлэх
- Лабораторийн мэдээлэлтэй хэрхэн холбогдох
- Тогтолцооны үйл ажиллагааг ямар үзүүлэлтээр, хэрхэн мэдээлэх, хянаж үнэлэх зэрэг асуудлуудыг гол болгосон билээ.

### *1.2 Эргэн дуудах тогтолцооны удирдамжийг хэрэглэгчид*

Сум, өрх, тосгоны ерөнхий мэргэжлийн эмч; их баригч, бага эмч, сувилагч, Аймаг, дүүргийн түвшний эх барих, эмэгтэйчүүдийн эмч, мэс заслын эмч, хавдар судлаач эмч, эмэгтэйчүүдийн хавдрын эмч, дүрс оношлогооны эмч, эс судлаач эмч, эмгэг судлаач эмч, хавдар бүртгэгч нар удирдамжийг өдөр тутмынхаа үйл ажиллагаандаа удирдлага болгон хэрэглэнэ. Монгол улсад умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэг, эргэн дуудах тогтолцооны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцож буй эрүүл мэндийн байгууллага, эмгэг судлалын болон эс судлалын лабораториуд энэхүү удирдамжийг арга зүйн лавлагаа болгоно.

Удирдамж нь 9 бүлгээс бүрдэх ба бүлэг тус бүрд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан болно.

### *1.3 Эргэн дуудах тогтолцооны удирдамжийн зорилго*

Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг, эргэн дуудах тогтолцооны удирдамжийн зорилго нь зохих насны эмэгтэйчүүдийг умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгт тодорхой хугацааны давтамжтайгаар эргэн дуудаж хамруулах тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлж, умайн хүзүү, хөхний өмөнгөөр өвдөх, эндэхээс сэргийлэхэд оршино.

### *1.4 Хамрах хүрээ*

Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгт 30-60 насны эмэгтэйг 3 насны давтамжтайгаар (30, 33, 36 ...60 нас) сонгон хамруулна. Мөн жирэмсний тээлтийн эхний 3 сарын хугацаанд буй 30-аас дээш насны жирэмсэн эмэгтэйг хамруулна. Харин хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгт ямар нэгэн шалтгаанаар эмнэлэгт хандсан эмэгтэйг хамруулахаас гадна болон хөхний өмөнгөөр өвдөх өндөр эрсдэлтэй эмэгтэйг нэмэлтээр хамруулна.

## 2. Удирдамжид оруулсан нэр томъёоны тодорхойлолт

### *2.1 Илрүүлэг (Screening)*

Эмнэлэгт хандах бодолгүй байсан хүмүүсийн дундаас тодорхой нэг эмгэгт өртөх эрсдэл бүхий хүнийг тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зорилготой хийгдэж байгаа үзлэг, шинжилгээг системтэйгээр зохион байгуулахыг скрининг буюу илрүүлэг гэнэ. Үзлэг шинжилгээ, бусад ажилбарын тусламжтай өвчний шинж тэмдэг илрээгүй, хараахан оношлогдоогүй байгаа өвчнийг илрүүлж, өвчний үйл явц нэгэнт эхэлсэн хүмүүсийг эрүүл хүмүүсээс ялган оношлох үйл ажиллагаа гэж бас тодорхойлдог.

Илрүүлэг нь хэд хэдэн янз байна.

- *<u>Системтэй илрүүлэг</u>:* Хүн амын тодорхой хэсгийн дунд өвчинд өртөх магадлал бүхий хүмүүсийг олж тогтоох. Энэ нь дараах хэд хэдэн хэлбэртэй. Үүнд:
  - Бүх нийтийн илрүүлэг - хүн амыг ямар нэгэн шалгуураар сонгохгүй, нийтэд нь үзлэг, шинжилгээнд хамруулах
  - Олон үе шаттай илрүүлэг - нэг хүнийг хэд хэдэн үе шаттай үзлэг, шинжилгээнд хамруулах
  - Олон өвчний илрүүлэг - хоёр буюу түүнээс олон өвчнийг нэг удаагийн илрүүлэг үзлэгээр илрүүлэхээр зорьсон
  - Энгийн илрүүлэг - нэг өвчнийг илрүүлэх
  - Сонгомол илрүүлэг - тодорхой эрсдэлт бүлгийн дунд өвчнийг илрүүлэх, тухайлбал нярай хүүхдэд төрөлхийн гажгийг илрүүлэх гм

- *<u>Зорилтот илрүүлэг</u>:* Орчны хортой нөлөөнд өртсөн бүлгийн дунд хийгдэх илрүүлэг, энэ нь хөдөлмөрийн болон орчны эрүүл ахуйд түгээмэл хэрэглэгддэг.

- *<u>Давтан илрүүлэг</u>:* Хүн амын тодорхой бүлэгт өмнө нь хийгдсэн илрүүлэг үзлэгээр оношлогдоогүй хүмүүсийг тогтоох. Өмнөх илрүүлгийн арга хэмжээгээр оношлогдохгүй байх нь голдуу шинжилгээний хариу хуурамч сөрөг байсантай холбоотой байдаг.

- <u>*Оппортунист /боломжит/ илрүүлэг*</u>: Өөр зорилгоор эрүүл мэндийн байгууллагад хандсан үйлчлүүлэгчид үзлэг, шинжилгээ хийх замаар ямар нэг өвчнийг илрүүлэхээр зорьсон үйл ажиллагаа.

### 2.2 Эрт илрүүлэлт (Early detection)

Хорт хавдрыг эрт үе шатанд нь илрүүлэх (оношлох)-ийг хэлнэ.

### 2.3 Эмнэлзүйн удирдамж

Эмнэлзүйн өвөрмөц нөхцөл байдалд тохирсон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар шийдвэр гаргахад эмч, өвчтөнд туслах зорилгоор системтэй боловсруулсан мэдээлэл. Эмнэлзүйн шийдвэр гаргахад шаардлагатай нотолгоог цуглуулж, хүчин төгөлдөр байдлыг нь үнэлж, нэгтгэх замаар удирдамжийг боловсруулдаг.

### 2.4 Хамралт

Бодитоор үзүүлсэн тусламж үйлчилгээ нь хамт олны хэрэгцээг хэрхэн хангаж байгааг илэрхийлдэг үзүүлэлт. Үүнийг тооцоход *хүртээр* нь тусламж үйлчилгээ авсан тохиолдлын тоо, харин *хуваарь* нь стандартын дагуу үйлчилгээ авах ёстой байсан тохиолдлын тоо байна.

### 2.5 Оношилгоо

Эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлох үйл явц. Оношилгоонд өвчний шалтгаан, эмгэг жам, хүнд хөнгөний зэргийг анхаарах хэрэгтэй.

### 2.6 Нотолгоо

Дүгнэлт, мэдэгдэл, итгэл үнэмшлийг баталсан баримт мэдээлэл.

### 2.7 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, хянах, сэргээх зорилгоор хувь хүн, олон нийтэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоо буюу мэргэжилтнүүдийн үзүүлж буй үйлчилгээ. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нь мэргэжлийн багийн үзүүлдэг өргөн хүрээтэй үйлчилгээ, үйл ажиллагаанаас бүрдэнэ. Харин эмнэлгийн тусламж гэдэг нь аль нэг эмчийн хяналтан дор хийгдэх оношилгоо, эмчилгээ.

### 2.8 Тусламж үйлчилгээний шатлал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гурван шатлал байдаг нь анхдагч буюу сум, өрх тосгоны эрүүл мэндийн төвийн амбулаторийн үйлчилгээ, хоёрдогч буюу аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн стационарийн үйлчилгээ, гуравдагч буюу төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг, төвийн үйлчилгээ юм.

### 2.9 Хувь хүнийг тодорхойлох үзүүлэлтүүд

Тухайн хүнийг ямар нэг эргэлзээгүйгээр тодорхойлж өгөх мэдээ (тухайлбал: овог нэр, регистрийн дугаар). Энэ нь засаг захиргааны өөр өөр эх сурвалжийн мэдээллийг хооронд нь холбоход чухал ач холбогдолтой.

### 2.10 Бүртгэл мэдээлэл

Хүн амын дунд байгаа болон шинээр гарч буй өвчний тохиолдлыг газар зүйн бүсээр нь тасралтгүй, бүрэн гүйцэд тэмдэглэх. Бүртгэлийг өргөжүүлсэн эрсдэлт хүчин зүйлд өртсөн боловч хараахан шинж тэмдэг илрээгүй хүмүүсийг хамруулж

болно. Бүртгэл мэдээлэл нь статистик ба тархварзүйн судалгааны чухал арга хэрэгсэл юм.

## 3. Хэрэглэгдэх өвчний ангилал

### *3.1 Умайн хүзүүний өмөнгийн илрүүлэг*

Умайн хүзүүний эмгэгийн хувьд Олон улсын хавдар өвчний ангилал (ӨОУА-ХС) болон Өвчний олон улсын 10-р ангиллын C53.0-C53.9 (өмөн), D06 (байран өмөн), N86 (умайн хүзүүний шархлаа ба шамраас), N87.0-N87.9 (дисплази), N88.0-N88.9 (умайн хүзүүний бусад үрэвсэлт бус өвчин) хэсгүүдийг голчлон ялган оношилгооны зорилгоор ашиглана.

### *3.2 Хөхний өмөнгийн илрүүлэг*

Хөхний эмгэгийн хувьд Олон улсын хавдар өвчний ангилал (ӨОУА-ХС) болон Өвчний олон улсын 10-р ангиллын C50.0-C50.9 (өмөн), D05-D05.9 (байран өмөн), N60.0-N64.9 (хөхний бусад өвчин) ангилалыг ашиглана.

## 4. Эргэн дуудах тогтолцооны мэдээлэх үйл явц

### *4.1 Мэдээний эх сурвалж байгууллагууд*

Монгол улсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудад хийгдсэн илрүүлэг үзлэг, шинжилгээний мэдээ, эс болон эмгэг судлалын лабораториудын шинжилгээний дүгнэлт зэргээс эргэн дуудах тогтолцооны мэдээлэл бүрдэх тул эдгээр байгууллагууд нь мэдээний эх сурвалж байгууллагууд болно.

### *4.2 Үйл ажиллагааны гүйцэтгэлийн тогтмол мэдээ*

Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгийн үйл явцыг мэдээлэх, эргэн мэдээлэхдээ умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлгийн маягтаар (Хавсралт 1, 2) мэдээлнэ.

### *4.3 Сар, жилийн тайланг мэдээлэх*

Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлгийн мэдээг Эргэн дуудах тогтолцооны үндэсний бүртгэлээс сар бүр мэдээлэхдээ дараа сарын 3-ны өдрийн дотор сарын тайлангийн маягтын хүрээнд (Хавсралт 4, 5) аймаг, дүүргийн Хавдар бүртгэгчид мэдээлнэ.

Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч тухайн жилийн илрүүлгийн мэдээг 12-р сарын 30-наар тасалбар болгон дараа оны 1 сарын 10-ны дотор Эргэн дуудах тогтолцооны үндэсний бүртгэлд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

### *4.4 Мэдээлэх, эргэн мэдээлэх*

Эргэн дуудах тогтолцооны үндэсний бүртгэлээс умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлгийн холбогдолтой бүхий л мэдээг өрхийн болон сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс авахуулаад аймаг, дүүрэг, хот улмаар үндэсний хэмжээнд гарган холбогдох яам, хэрэгжүүлэгч агентлаг байгууллагуудыг мэдээллээр хангах ба улмаар эргэн дуудах тогтолцооны бүртгэл, мэдээллийн эх сурвалж байгууллагуудыг эргэн мэдээллээр хангана.

Сар бүр Эргэн дуудах тогтолцооны мэдээллийн төвөөс дараа сарын 5-ны өдрийн дотор ЗГХА-ЭМГ-ын ЭМСХ-ээс эрхлэн гаргадаг "Хүн амын өвчлөл, эндэгдлийн мэдээлэл" сарын мэдээний товхимолд аймаг, дүүргийн илрүүлэг үзлэгийн мэдээг өссөн дүнгээр нийтлүүлнэ.

Эргэн дуудах тогтолцооны үндэсний бүртгэл нь илрүүлэгтэй холбогдох мэдээ, тайланг нэгтгэн ЗГХА-ЭМГ-ын ЭМСХэлтэст дараа оны 2-р сарын 15-ны дотор мэдээлнэ. "Эрүүл мэндийн үзүүлэлт" жилийн номонд аймаг, дүүргийн илрүүлгийн жилийн мэдээг нийтлүүлнэ.

***4.5 Эргэн дуудах тогтолцоонд хэрэглэгдэх програм хангамж***

Үндэсний хэмжээнд Эргэн дуудах тогтолцоонд зориулан гаргасан тусгай программ хангамжийг хэрэглэнэ. Илрүүлгийн явцад хорт хавдар оношлогдвол Хавдрын үндэсний бүртгэлд автоматаар мэдээлнэ. Мөн энэхүү програмаас Монгол улсын эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоонд хэрэглэгдэж буй бүх програм (Health-Info...) руу шаардлагатай мэдээллийг чөлөөтэй хөрвүүлэн ашиглана.

**5. Мэдээний чанарын хяналт**

***5.1 Эргэн дуудах тогтолцооны үндэсний бүртгэл нь*** мэдээний эх сурвалж байгууллагуудад Эргэн дуудах тогтолцооны удирдамж, гарын авлагыг мөрдөж байгаа байдал болон мэдээний чанарын шалгуур үзүүлэлтэд хяналт тавина. Мөн илрүүлгийн мэдээний чанарын талаар үйл ажиллагааны нэгжүүдэд арга зүйгээр хангах, зөвлөгөө заавар өгөх, сургах үүрэгтэй.

Эмч, мэргэжилтнүүд нь илрүүлгийн мэдээг гарын авлагад заасан хугацаа, зааврын дагуу мэдээлээгүй нь батлагдсан тохиолдолд холбогдох хууль, дүрмийн дагуу хариуцлага хүлээнэ. Мөн хавдар бүртгэгч нь илрүүлгийн мэдээг мэдээлээгүй, удирдамж ба гарын авлагыг дагаж мөрдөөгүй ажил үүргээ цалгардуулсан, мэдээллийн урсгал, хугацааг зөрчсөн ноцтой алдаа гаргасан нь нотлогдвол холбогдох хууль, дүрмийн дагуу хариуцлага хүлээнэ.

***5.2 Мэдээний чанарын шалгуур үзүүлэлт***

- Эргэн дуудах тогтолцооны удирдамжийг мөрдөж байгаа эсэх
- Илрүүлгийн хэрэгжүүлэлтийн гарын авлагыг мөрдөж байгаа эсэх
- Мэдээний үнэн зөв, бүрэн байдал
- Мэдээний чанарын үзүүлэлт болох /илрүүлгийн хамралтын хувь, эсийн шинжилгээний давтан хийгдсэн шалтгаан, түүний хувь/ зэргийг тооцож байх
- Цаг хугацаандаа мэдээлэгдэж байгаа эсэх

**6. Мэдээ, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал**

***6.1*** Эргэн дуудах тогтолцооны бүртгэлээс гарах мэдээ, мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарагдах тул мэдээг мэдээлж байгаа эмнэлгийн мэргэжилтнээс эхлээд Эргэн дуудах тогтолцооны үндэсний бүртгэл хүртэлх бүх түвшинд мэдээллийн нууцыг холбогдох хуулийн дагуу чанд хадгална.

***6.2*** Судалгаа, шинжилгээний зориулалтаар мэдээллийг гаргахдаа хувь хүний мэдээлэлтэй холбоотой хэсгийг нууцална.

***6.3*** Мэдээ, мэдээллийн нууцтай холбоотой санал гомдлыг ЭМЯ-ны ёс зүйн хороо болон аймаг, нийслэлийн ёс зүйн салбар хороо хүлээн авч шийдвэрлэнэ.

***6.4*** Илрүүлгийн маягт хадгалах хугацаа, жилээр

| № | Илрүүлгийн маягтын нэр, дугаар | Цаасан | Цахим |
|---|---|---|---|
| 1 | Умайн хүзүүний өмөнгийн илрүүлгийн маягт **(СМУ-1)** | 10 | 20 |
| 2 | Хөхний өмөнгийн илрүүлгийн (ХЭҮ) маягт **(СМХ-1)** | 10 | 20 |
| 3 | Умайн хүзүүний өмөнгийн илрүүлгийн маягт **(СМ-У-2)** | 10 | 20 |
| 4 | Хөхний өмөнгийн (ХЭҮ) илрүүлгийн маягт **(СМ-Х-2)** | 10 | 20 |
| 5 | Умайн хүзүүний эсийн шинжилгээний маягт **(СМУ-1/Эс)** | 20 | 30 |
| 6 | Хөхний эсийн шинжилгээний маягт **(СМХ-1/Эс)** | 20 | 30 |
| 7 | Умайн хүзүүний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМУ-2/Эд)** | 20 | 30 |
| 8 | Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМХ-2/Эд)** | 20 | 30 |
| 9 | Маммографи шинжилгээний маягт **(СМ-Х-3)** | 10 | 20 |

## 7. Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг, эргэн дуудах тогтолцооны дэд бүтэц

*7.1 Санхүүжилт*

- Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг, эргэн дуудах тогтолцооны мэдээллийн үйл ажиллагаа нь улсын төсөв болон бусад санхүүгийн эх үүсвэрээр санхүүжих болно.
- Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг, эргэн дуудах тогтолцооны үндэсний бүртгэл, аймаг дүүргийн илрүүлгийн үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийг байгууллагууд жил бүрийн төсөвдөө тусган ажиллах үүрэгтэй.

*7.2 Хүний нөөц*

- Мэдээний эх сурвалж байгууллагууд нь Хорт хавдрын бүртгэл, Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг, эргэн дуудах тогтолцооны мэдээллийн чиглэлээр сургагдсан хавдар бүртгэгчийг ажиллуулна.
- Хавдар бүртгэгчийг мэргэжлийн сургалтанд хамруулах, ажиллах орчны нөхцлийг хангах талаар тухайн байгууллагын удирдлагын зүгээс дэмжиж ажиллана.
- Хавдар бүртгэгчийг мэргэшүүлэх сургалтыг тусгай зөвшөөрөл, эрх авсан байгууллага эрхлэн явуулна.

*7.3 Техник хангамж*

- Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг,эргэн дуудах тогтолцооны үндэсний бүртгэл нь орчин үеийн шаардлага хангасан компьютер, принтер, сканнер зэргээс гадна тусгай програм хангамжаар хангагдсан байна.
- Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг,эргэн дуудах тогтолцооны үндэсний бүртгэл нь мэдээ, мэдээллээ түргэн шуурхай солилцох үүднээс суурин утас, факсын аппарат, интернэтээр хангагдсан байх шаардлагатай.
- Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг,эргэн дуудах тогтолцоо нь Монгол улсын Эрүүл мэндийн салбарт болон олон улсын түвшинд хэрэглэгдэж буй програм хангамжтай дүйцэхүйц програмыг ашиглана. Энэ програм нь эрүүл мэндийн мэдээллийн чиглэлээр одоо хэрэглэгдэж байгаа Health-Info зэрэг програмд чөлөөтэй хөрвөж, шаардлагатай мэдээ, мэдээллийг гарган өгөх боломжтойгоор хийгдсэн байх болно.

## 8. Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгийг явуулах, бүртгэх мэдээлэх үйл ажиллагаа

***Удиртгал***

Монгол улсын засгийн газрын Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-наас умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлгийн талаархи бодлогыг бий болгож, хэрэгжүүлэхээр шийдсэн юм.

***Умайн хүзүүний өмөн:***

ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсийн хөгжингүй болон хөгжиж буй орнуудтай харьцуулахад Монгол улсад умайн хүзүүний өмөнгийн өвчлөлийн түвшин өндөр байна. Умайн хүзүүний өмөн нь Монгол улсад эмэгтэй хүн амын дунд зонхилон тохиолдож буй өмөнгийн 2 дугаар байранд ордог ба нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг байсаар ирсэн билээ. Үндэсний хэмжээний хавдрын бүртгэлийн мэдээллээс харахад, 2009 онд Монгол улсад Умайн хүзүүний өмөнгийн өвчлөлийн шинэ тохиолдлын түвшин 19.2, нас баралтын түвшин 7.7 (100.000 эмэгтэй хүн амд) тус тус бүртгэгдсэн байна. Умайн хүзүүний өмөнгийн өвчлөлийн шинэ тохиолдлын 67.5%, нас баралтын тохиолдлын 62.3% нь хөдөө, орон нутгаас бүртгэгдсэн байна.

Умайн хүзүүний өмөнгийн өвчлөл өндөр байгаагийн гол шалтгаан нь өмөн үүсгэгч Хүний папиллома вирүс (ХПВ)-ийн халдварын тохиолдол нь бэлгийн идэвхитэй амьдралд байгаа эмэгтэйчүүдийн дунд өндөр байгаатай холбоотой байж болох юм. Тухайлбал, Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн дунд 2008 онд хийгдсэн ХПВ-ийн ДНК оношлуур ашиглаж хийсэн судалгаагаар 25-аас доош насны эмэгтэйчүүд (48.5%)-ийн дунд ХПВ-ийн халдварын тархалт нь 35% байжээ.

Эдгээр эмэгтэйчүүдийн 24.5% нь өмөн үүсгэх өндөр эрсдэл бүхий омгийн вирүсээр халдварлагдсан байна.[1] Мөн хожуу үе шатандаа оношлогдсоноос нас баралтын түвшин өндөр байна. Эдгээрээс хамаарч олон зорилтот арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно. Үүнд: хүн амд зөвлөгөө өгөх, ялангуяа залуучуудад аюулгүй бэлгийн амьдрал, бэлгэвчийг хэрэглэх талаар сурталчилах, ХПВ-ийн вакциныг нэвтрүүлэх зэрэг болно. Эдгээр арга хэмжээ нь 30 хүртэлх насныханд зориулсан бүрэн төгс үйл ажиллагаа болж чадахгүй хэдий ч хүн амын дунд тохиолдох умайн хүзүүний өмөнгийн тохиолдлыг багасгахад нөлөөлөх болно (анхдагч урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээгээр тохиолдлыг 70% бууруулдаг болох нь онолын дагуу тогтоогджээ). Мөн түүнчлэн эрт үе шатанд нь илрүүлэх, оношлоход чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй. Ингэснээр хавдрын урьдал эмгэг болон умайн хүзүүний өмөнгөөр өвдсөн эмэгтэйчүүдийн өвчний эдгэрэлт, эмчилгээний үр дүнг сайжруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Хүн амд суурилсан умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгт 30-60 насны бүх эмэгтэйчүүдийг 3 жилд 1 удаа хамруулна.
- Жирэмсний эхний 3 сарын хугацаанд буй 30-аас дээш насны бүх жирэмсэн эмэгтэйг боломжит илрүүлэг үзлэгт хамруулна.

***Хөхний өмөн:***

Монгол улсад Хөхний өмөнгийн өвчлөлийн түвшин нь ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсийн бусад хөгжингүй болон хөгжиж буй орнуудтай харьцуулахад харьцангуй бага бүртгэгддэг. Үндэсний хэмжээний хавдрын бүртгэлийн мэдээллээс харахад, 2009 онд Монгол улсад хөхний өмөнгийн өвчлөлийн шинэ тохиолдлын түвшин 5.8, нас баралтын түвшин 2.6 (100.000 эмэгтэй хүн амд), өвчлөлийн шинэ тохиолдлын 40.3%, нас барсан тохиолдлын 54.1% нь хөдөө, орон нутгаас бүртгэгджээ.

Үүний шалтгааныг тодорхойлсон нарийн судалгаа хараахан хийгдээгүй. Энэ нь Монгол эмэгтэйчүүдийн дунд төрөлт, хүүхдээ хөхөөр хооллолт өндөр байдагтай холбоотой байж болох юм. Умайн хүзүүний өмөнгийн нэгэн адил хөхний өмөн хожуу үе шатандаа оношлогдсоноос нас баралтын түвшин өндөр байна. Хүн амд суурилсан илрүүлэг нь өртөг өндөртэй учраас ДЭМБ-аас илрүүлэгийг хийхийг зөвлөдөггүй. Үүний оронд аль болох энгийн, хорт хавдрыг аль болох эрт үе шатанд нь оношлох, хөхөө өөрөө шинжих аргыг хэрэглэх, хөхний эмнэлзүйн үзлэг (ХЭҮ)-ээр боломжит илрүүлэгийг зохион байгуулах нь зүйтэй хэмээн зөвлөдөг. Үүнд:

- Ямар нэгэн шалтгаанаар Өрх, сумын эмчид хандсан эмэгтэй бүрт ХЭҮ-ээр боломжит илрүүлэгийг хийх

Мөн эмэгтэй "Хөхөө өөрөө шинжих арга"-аар хөхөө шинжих үед бэрсүү, үүсгэвэр илэрвэл өрх, сумын эмчдээ хандан ХЭҮ хийлгэх хэрэгтэй. Хөхний өмөнгөөр өвдөх өндөр эрсдэлтэй зарим эмэгтэйчүүдийн хувьд тодорхой хугацааны давтамжтайгаар байнга маммографийн шинжилгээ бүхий илрүүлэг үзлэгт хамрагдах шаардлагатай. Тухайлбал: Урьд нь өөрөө хөхний өмөнгөөр өвдөж байсан, ойрын садан төрөл (ээж, эгч, охин дүү) нь хөхний өмөнгөөр өвдсөн дурьдатгалтай эмэгтэйчүүд хөхний өмөнгөөр өвдөх өндөр эрсдэлтэйд тооцогдон маммографийн шинжилгээнд суурилсан илрүүлэг үзлэгт жил бүр хамрагдах болно.

*Баримтлах бодлогын баримт бичиг*

Умайн хүзүү болон хөхний өмөнгийн урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, хяналтын эмнэлзүйн удирдамжуудыг 2011 онд боловсруулж, Монгол улсын эрүүл мэндийн сайдын -2011 оны 168 тоот тушаалаар батлуулсан. Эдгээр нь:

- УМАЙН ХҮЗҮҮНИЙ ӨМӨН: Урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, тохиолдлын зохицуулалт, хяналт ба хөнгөвчлөх эмчилгээ - Монгол улсын Эмнэл зүйн удирдамж
- ХӨХНИЙ ӨМӨН: Урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, тохиолдлын зохицуулалт, хяналт ба хөнгөвчлөх эмчилгээ - Монгол улсын Эмнэл зүйн удирдамж болно.

Эдгээр удирдамжууд дээр үндэслэн илрүүлэг үзлэгийг алхам алхамаар, илрүүлгийн маягтаар бүртгэнэ.

| Өрх, сум тосгоны ЭМТ: Өрх, сум тосгоны эмч | Маягтын дугаар |
|---|---|
| Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгийн бүртгэл<br>Умайн хүзүүний өмөнгийн илрүүлгийн маягт<br>Хөхний өмөнгийн илрүүлгийн (ХЭҮ) маягт<br>Умайн хүзүүний эсийн шинжилгээний маягт | АМ-1Д<br>(СМУ-1)<br>(СМХ-1)<br>(СМУ-1/Эс) |
| **Аймгийн НЭ, дүүргийн ЭМН: Эх барих, эмэгтэйчүүдийн эмч** | |
| Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгийн бүртгэл<br>Умайн хүзүүний өмөнгийн илрүүлгийн маягт<br>Умайн хүзүүний эдийн шинжилгээний сорьцын маягт | АМ-1Д<br>(СМ-У-2)<br>(СМУ-2/Эд) |
| **Аймгийн НЭ, дүүргийн ЭМН: Мэс заслын болон хавдрын эмч** | |
| Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгийн бүртгэл<br>Хөхний өмөнгийн (ХЭҮ) илрүүлгийн маягт<br>Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт | АМ-1Д<br>(СМ-Х-2)<br>(СМХ-2/Эд) |
| **Аймгийн НЭ, дүүргийн ЭМН: Эс судлаач** | |
| Умайн хүзүүний эсийн шинжилгээний маягт<br>Хөхний эсийн шинжилгээний маягт | (СМУ-1/Эс)<br>(СМХ-2/Эс) |
| **Аймгийн НЭ, дүүргийн ЭМН: Эмгэг судлаач** | |
| Умайн хүзүүний эдийн шинжилгээний сорьцын маягт<br>Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт | (СМУ-2/Эд)<br>(СМХ-2/Эд) |
| **Аймгийн НЭ, дүүргийн ЭМН: Дүрс оношлогооны эмч (ЭХО, рентген)** | |
| Маммографи шинжилгээний маягт | (СМ-Х-3) |

*Эргэн дуудах тогтолцооны илрүүлгийн маягтууд*

Эргэн дуудах тогтолцооны илрүүлгийн маягтууд нь эрүүл мэндийн салбарын шатлал тус бүрт тохирсон байдлаар хэрэглэгдэнэ. Анхдагч ба хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд илрүүлэг үзлэгийг "Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгийн бүртгэл" **АМ-1Д** маягтад бүртгэнэ. Үзлэгээр илэрсэн эмгэгийн оношийг удирдамжид заасан хэрэглэгдэх ангилалын дагуу кодлоно. Газар нутгийн байршил, хаяг болон эмнэлгийн нэрийг кодлохдоо Эрүүл мэндийн сайдын 2010 оны 34 тоот тушаалд заасны дагуу кодлоно. Эдгээр бүх илрүүлгийн маягтууд нь энэхүү гарын авлагын мэдээллийн урсгалын алгоритмтай уялдана. Мөн эдгээр маягтууд нь одоо хэрэглэгдэж байгаа ямар нэгэн маягтыг өөрчлөөгүй, харин мэдээллийг нэмэлтээр агуулсан юм. Жишээ нь: Эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл нь зөвхөн эмнэлгийн бүртгэлийн маягт дээр тэмдэглэгдэх ёстой.

**УМАЙН ХҮЗҮҮНИЙ ӨМӨНГИЙН ИЛРҮҮЛЭГ**

**1-р алхам: Үйлчлүүлэгчийг тодорхойлох, дуудах, илрүүлэг үзлэгт урих**

**Зорилго ба агуулга**

30-60 насны эмэгтэйчүүдийг 3 насны давтамжтайгаар (30, 33, 36 ....60) умайн хүзүүний илрүүлэг үзлэгт хамруулна. Мөн жирэмсний эхний 3 сарын хугацаанд хянагдаж буй 30-аас дээш насны жирэмсэн эмэгтэйг хамруулна. Илрүүлэг үзлэгийг Пап шинжилгээний аргаар хийх ба энэ нь сонгогдсон эмэгтэйн хувьд гурван жил тутамд нэг удаа хийгдэнэ. Эмэгтэйчүүдийг илрүүлэг үзлэгт хамруулахаар урихдаа 30, 33 ... гэх мэтээр 60 насны төрсөн өдрөө тэмдэглэсний нь дараа сард нь дуудан хамруулна. Илрүүлгийн эхний алхамын зорилго бол сонгосон үйлчлүүлэгчийг тодорхойлох, эрж хайх болон илрүүлэг үзлэгт дуудан хамруулахад оршино.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Монгол улсын 30-аас дээш насны бүх эмэгтэйчүүдийн мэдээллийг Өрх, сум тосгоны ЭМТ-ийн Хүн амын мэдээллийн сангийн мэдээлэлд суурилан програмд байршуулсан байна. Авсан нэрсийн жагсаалтаас урьдах сард 30, 33 ..... 60 насных нь төрсөн өдөр нь болсон бүх эмэгтэйг сонгон бүртгэж авна.
- Хүн амын мэдээллийн сангаас авсан эмэгтэй бүрийн нэрийг бусад өрх, сум тосгоны эмчийн тулгасан нэрсийн жагсаалттай тулгаж магадлана. Тулгаж магадласан нэрсийн жагсаалтыг гаргаад, аймаг дүүргийн хавдар бүртгэгч тус бүрт цахим байдлаар түгээнэ.
- Аймаг, дүүргийн хавдар бүртгэгчээс буцаж ирсэн нэрсийн жагсаалтыг өрх, сум тосгоны эмчийн олж, тодруулж чадаагүй нэрсийг цаашид эрэн сурвалжлахад хэрэглэнэ. Харин "Нэмэлт үйлчлүүлэгч" бүхий нэрсийн жагсаалтыг бусад өрх, сумын эмч нараас ирсэн нэрсийн жагсаалттай

**Өрх, сум тосгоны эмч**

- Өрх, сумын эмч тухайн аймаг, дүүргийн хавдар бүртгэгчээс илгээсэн нэрсийн жагсаалтад тулгалт хийж, ямар үйлчлүүлэгч жагсаалтад орсон эсвэл ороогүй болохыг баталгаажуулна. Баталгаажуулсан мэдээг нэгдүгээр сарын 15-ны дотор хавдар бүртгэгчид буцаан илгээсэн байна. Нэрсийн жагсаалтад тулгалтыг "**Хүн амын мэдээллийн шинэчилсэн бүртгэлийн хуудас**"-аар жилд 2 удаа хийж, сар бүрийн эхний 5-ны дотор Эргэн дуудах тогтолцооны програмын жагсаалтаас нэрсийн жагсаалтыг шинэчилнэ.
- Зорилтот насны бүлэгт хамаарах үйлчлүүлэгчийг жагсаалтад нэмэлтээр хамруулна.
- Эдгээр нэрсийн жагсаалт бүхий цаасан бүртгэлийг хөтлөөд аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид илгээнэ.
- Өрх, сумын эмчийн гаргасан нэрсийн дагуу үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн ажилтан (нийгмийн ажилтан, өрхийн

тулгаж, бүртгэлийг шинэчилнэ.

- Шаардлагатай тохиолдолд нэмэлт нэрсийн жагсаалтыг буцаан илгээнэ.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Тухайн аймаг, дүүргийн хүн амын мэдээллийг "Хүн амын мэдээллийг эргэн тулгах хүснэгт" ашиглан жил бүрийн нэгдүгээр сарын 5-ны өдрийн дотор татан авч, улмаар бүх сум, өрхийн эмнэлгээс хамруулбал зохих эмэгтэйчүүдийн нэрсийн жагсаалтыг "**Хүн амын мэдээллийн шинэчилсэн бүртгэлийн хуудас"**-ны дагуу шүүн гаргана.
- Жил бүрийн нэгдүгээр сарын 10-ны дотор эмэгтэйчүүдийн нэрсийг цахим бүртгэлтэй тулгалт хийхийн тулд тухайн аймгийн Өрх, сумын эмч тус бүрт илрүүлэг үзлэгт хамруулбал зохих эмэгтэйн нэрсийн жагсаалтыг хэвлэсэн байдлаар түгээнэ.
- Нэрсийн жагсаалт бүхий цаасан маягтаас нэр нь ороогүй нэмэлт нэрс болон нэр нь байгаа хэрнээ хаяг дээрээ байхгүй байгаа нэрсийг тодруулан Өрх, сумын эмчийн гаргасан шинэчилсэн нэрсийн жагсаалтыг Эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд оруулна.

сувилагч, багийн бага эмч, эх баригч) болон сайн дурын ажилтнуудаар дамжуулан холбоо тогтооно.

- Үйлчлүүлэгчийг урихдаа илрүүлэг үзлэгт хэрхэн хамрагдах талаар заавар, зөвлөмж бүхий урилгыг түгээнэ.
- Үйлчлүүлэгчийг өрх, сум болон багийн эмнэлэгт эхний удаа Пап шинжилгээ өгөх, 2-4 долоо хоногийн дараа шинжилгээний хариу авахын тулд заавал дахин ирэх ёстой гэдгийг сануулна.



### 2-р алхам: Пап шинжилгээ авах

**Зорилго ба агуулга**

Энэ алхам нь өрх, сум тосгоны ЭМТ дээр үйлчлүүлэгчдээс Пап шинжилгээ авч, шинжилгээний наацыг эс судлалын лабораторид илгээн, эргэн дуудах тогтолцоонд мэдээлэх үйл явцыг хамарна.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Өрх, сум тосгоны эмч**

- Эмэгтэйн эхний ирэлтээр, удирдамжид заасны дагуу Пап шинжилгээг авна, **(СМУ-1)** маягтыг хөтлөн аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид илгээнэ.
- Наац бэлдсэн шил, Умайн хүзүүний эсийн шинжилгээний маягт **(СМУ-1/Эс)**-ыг хөтөлж, эс судлалын лабораторид илгээнэ.
- Үйлчлүүлэгчид 2-4 долоо хоногийн дараа шинжилгээний хариугаа авахаар ирээрэй хэмээн сануулна.

**Эс судлаач**

- Наац бэлдсэн шилийг хүлээн авч, Умайн хүзүүний эсийн шинжилгээний маягт **(СМУ-1/Эс)**-ыг лабораторийн бүртгэлд бүртгэж авна.
- Удирдамжид заасны дагуу шинжилгээний материалыг будаж боловсруулна, дараа нь шинжилгээний дүгнэлтийг гаргаж, хариуг Умайн хүзүүний эсийн шинжилгээний маягт **(СМУ-1/Эс)**-д бөглөж, аймаг дүүргийн хавдар бүртгэгчид цаасан байдлаар илгээнэ.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Илрүүлгийн цаасан маягтуудын мэдээг эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлийн маягтад оруулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Маягтууд дахь мэдээллийг бүртгэнэ.
- Хэрэв үзлэг, шинжилгээгээр хавдар мэдээлэгдсэн байвал хавдрын үндэсний бүртгэлд автоматаар мэдээлэгдэнэ.

**Хавдрын үндэсний бүртгэл**

- Өрх, сумын эмчээс тодотгож өгсөн, хавдартай холбоотой мэдээллийг цуглуулна.
- Үйлчлүүлэгчийн нэрийг хяналтад байлгах нэрсийн жагсаалтад оруулна (цаашид шаардагдах мэдээллийг идэвхитэйгээр бүртгэж авахын тулд)



### 3-р алхам. Пап шинжилгээний дүгнэлтийг мэдээлэх

*3.0 алхам: Ерөнхий мэдээлэл*

**Зорилго ба агуулга**

Энэ алхам нь эс судлаачийн өгсөн дүгнэлтийн хүрээнд Пап шинжилгээний хариуг мэдээлэх эхний хэсэг болно.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Өрх, сум тосгоны эмч**

- Шинжилгээний хариуг хүлээн авна.
- Үйлчлүүлэгчийг тогтсон хугацаандаа буцаж ирэнгүүт шинжилгээний хариуг нь мэдээлнэ.
- Хэрэв шинжилгээний хариу хэвийн гарсан, 60 наснаас хэтрээгүй байвал, холбогдох мэдээллийг өгөөд 3 жилийн дараа дуудсан цагт ирж, давтан Пап шинжилгээнд хамрагдахыг зөвлөн буцаана.
- Хэрэв шинжилгээний хариу хэвийн гарсан, 3 жилийн дараа үйлчлүүлэгч 61 ба түүнээс дээш настай байхаар байвал, түүнийг эргэн ирж үзүүлэхээр дуудах боловч харин ямар нэгэн шинж тэмдэг илрээгүй тохиолдолд давтан Пап шинжилгээ авах шаардлагагүй.

**Эс судлаач**

- Пап наацад шинжилгээ хийж, дүгнэлт өгнө
- Эсийн шинжилгээний дүгнэлтийг Умайн хүзүүний эсийн шинжилгээний маягт **(СМУ-1/Эс)**-д бичиж, аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид мэдээлнэ.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд **(СМУ-1)** болон Умайн хүзүүний эсийн шинжилгээний маягт **(СМУ-1/Эс)**-ын мэдээллийг оруулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Шинээр хөтлөгдсөн маягтуудыг бүртгээд, урьд хүлээж авсан маягтуудтай холбон судалж, давхардал байгаа эсэхийг магадлана.
- Хэрэв үзлэг, шинжилгээгээр хавдар мэдээлэгдсэн байвал хавдрын үндэсний бүртгэлд автоматаар мэдээлэгдэнэ.

**Хавдрын үндэсний бүртгэл**

- Эс судлаач болон Өрх, сумын эмчийн тодотгож өгсөн, хавдартай холбоотой мэдээллүүдийг цуглуулна.
- Үйлчлүүлэгчийн нэрийг хяналтад байлгах нэрсийн жагсаалтад оруулна (цаашид шаардагдах мэдээллийг идэвхитэйгээр бүртгэж авахын тулд)



### *3.1 алхам: Шинжилгээний бэлдэц шаардлага хангахгүй тохиолдлын зохицуулга*

**Зорилго ба агуулга**

Эс судлаач эмчийн зүгээс Пап шинжилгээ техникийн хувьд шаардлага хангахгүй (эс цөөн, цус ихтэй, дүгнэлт өгөх боломжгүй) гэж мэдээлсэн байвал, шинжилгээг давтан авна.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Өрх, сумын эмч**

- Үйлчлүүлэгчийн ирэх хугацааг урьдчилан тохирсны дагуу 2-р алхамаас дахин эхлэнэ.



### *3.2 алхам: Умайн хүзүүний үрэвслийн үеийн зохицуулга*

**Зорилго ба агуулга**

Эсийн шинжилгээгээр үрэвсэл, БЗХ-тай гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд үйлчлүүлэгчийг Эх барих, эмэгтэйчүүдийн эмчид илгээж эсвэл өрх, сумын эмч өөрөө эмчилгээ хийсний дараа давтан Пап шинжилгээ авна.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Өрх, сум тосгоны эмч**

- Үйлчлүүлэгч тогтсон хугацаандаа шинжилгээний хариугаа авахаар ирэхэд нь үтрээний халдвар, үрэвсэл оношлогдсон тухай мэдэгдэнэ.
- Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас **(АМ-13А)** бичиж үйлчлүүлэгчид өгөөд, эх барих, Эх барих, эмэгтэйчүүдийн эмчид илгээнэ.
- Үйлчлүүлэгчид "Та Эх барих, эмэгтэйчүүдийн эмчид очиж, эмчлүүлээд эргэн ирж давтан Пап шинжилгээ өгөх ёстой" гэдгийг сануулна.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Давтан авсан эсийн шинжилгээний хариуг Умайн хүзүүний эсийн шинжилгээний маягт **(СМУ-1/Эс)**-д тэмдэглэсэн байдлаар өрх, сум тосгоны эмчид илгээнэ.
- Цаасан бүртгэлийн маягтын мэдээллүүдийг цахим бүртгэлд оруулна.

**Эх барих, эмэгтэйчүүдийн эмч**

- Оношлогдсон эмгэгээс хамаараад үйлчлүүлэгчид тохирох эмчилгээг хийнэ.
- Үйлчлүүлэгчид эмчилгээ хийж дууссаны дараа Пап шинжилгээг давтан авч, наацыг эс судлалын лабораторид илгээж, хариуг хавдар бүртгэгчид илгээнэ.
- 



***3.3 алхам: Хавдрын сэжигтэй тохиолдлын зохицуулга***

**Зорилго ба агуулга**

Хавдрын урьдал эмгэг болон хавдрын сэжиг бүхий эмгэг өөрчлөлт оношлогдсон тохиолдолд үйлчлүүлэгч үтрээн дурангийн шинжилгээг эдийн шинжилгээний хамт өгөх ёстой.

**3.3 алхам: Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Өрх, сум тосгоны эмч**

- Илэрсэн эмгэг өөрчлөлтийн талаархи мэдээг үйлчлүүлэгчид мэдэгдэнэ.
- Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас **(АМ-13А)** бичиж үйлчлүүлэгчид өгөөд, яаралтай Эх барих, эмэгтэйчүүдийн эмчид илгээнэ.
- Аймаг, дүүргийн хавдар бүртгэгчээс илгээсэн өвчтний талаархи сануулгыг хүлээн авч, арга хэмжээ авсан эсэхээ програмд оруулж баталгаажуулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Эсийн шинжилгээний хариугаар эмгэг өөрчлөлт илэрснээс дараагийн үзлэг, шинжилгээ болох үтрээн дурангийн шинжилгээнд хамрагдсан боловч цаашдын үйл ажиллагааны мэдээ нь Эх барих, эмэгтэйчүүдийн эмчээс 4 долоо хоногийн дотор эргэн дуудах тогтолцооны програмд орж ирээгүй тохиолдолд тухайн аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид автоматаар цахим сануулга илгээгдэнэ.
- Улмаар эхний сануулгын хүрээнд Эх барих, эмэгтэйчүүдийн эмчээс дахин 4 долоо хоногийн дотор мэдээ орж ирээгүй байвал, 2 дахь сануулга автоматаар илгээгдэнэ.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Цахим сануулгыг хүлээн авч, цаасан сануулга болгон Өрх, сум тосгоны эмчид илгээнэ.
- Өрх, сум тосгоны эмчээс ирсэн, цаасан дээр бичигдсэн хариу баталгаар эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд оруулна.



## 4-р алхам: Үтрээн дурангийн болон эдийн шинжилгээ

**Зорилго ба агуулга**

Пап шинжилгээгээр хавдрын сэжигтэй гарсан тохиолдолд үтрээн дурангийн шинжилгээний хяналтан дор эдийн шинжилгээ авч хавдрын урьдал эмгэг эсвэл хорт хавдар байгаа эсэхийг тогтооно. Улмаар үйлчлүүлэгчийг хяналтад авах уу, шууд эмчилгээнд оруулах уу гэдгийг шийдвэрлэнэ.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Эх барих, эмэгтэйчүүдийн эмч**

- Удирдамжид заасны дагуу үтрээн дурангийн хяналт дор эдийн шинжилгээ авна.
- Эдийн шинжилгээний сорьцыг Умайн хүзүүний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМУ-2/Эд)**-ын хамт эмгэг судлалын лабораторид илгээнэ.
- Эмэгтэйчүүдийн эмчийн хөтлөх тусгай маягт **(СМУ-2)**-ыг цаасаар хөтлөөд аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид илгээнэ.
- Үйлчлүүлэгчид 2 долоо хоногийн дараа эргэн ирж, шинжилгээний хариуг авахыг мэдэгдэнэ.

**Эмгэг судлаач**

- Сорьцыг хүлээн авч, Умайн хүзүүний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМУ-2/Эд)**-ыг бүртгэн авна.
- Удирдамжид заасны дагуу шинжилгээний материалыг будаж боловсруулна, дараа нь шинжилгээний дүгнэлтийг гаргана.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Эрт илрүүлгийн цаасан маягтын мэдээг эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд оруулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Илрүүлгийн маягтуудыг бүртгэнэ.
- Хэрэв өмөн оношлогдсон тухай мэдээлсэн байвал Хорт хавдрын үндэсний бүртгэлд автоматаар мэдээлнэ.

**Хавдрын үндэсний бүртгэл**

- Эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эс судлаач болон Өрх, сум тосгоны эмчийн тодотгож өгсөн, хавдартай холбоотой мэдээллүүдийг цуглуулна.
- Хяналтад байлгах нэрсийн жагсаалтад үйлчлүүлэгчийн нэрийг оруулна (цаашид шаардагдах мэдээллийг идэвхитэйгээр бүртгэж авахын тулд)



## 5-р алхам: Үтрээн дурангийн шинжилгээний дүгнэлт дээр тулгуурлан хийх эхний зохицуулга

**Зорилго ба агуулга**

Үйлчлүүлэгч өрх, сум болон багийн эмчдээ үтрээн дурангийн шинжилгээ болон эмгэг судлалын (эдийн) шинжилгээний хариугаа авахаар эргэн ирнэ, хэрэв цаашид хяналтад авах шаардлагатай бол үйлчлүүлэгчийг эх барих, эмэгтэйчүүдийн эмчид явуулна. Эх барих, эмэгтэйчүүдийн эмч удирдамжид заасны дагуу хяналтыг цаашид хэрхэн үргэлжлүүлэх талаар шийдвэр гаргана.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Өрх, сум тосгоны эмч**

- Цаашид үйлчлүүлэгчид чиглэсэн аливаа нэгэн үйл ажиллагаа шаардлагатай гэж үзвэл, үйлчлүүлэгчид үзлэг, шинжилгээний хариу, дүгнэлтийг мэдэгдэж, **(АМ-13А)** хуудсыг хөтлөн эмэгтэйчүүдийн эмчид илгээнэ.
- Харин үзлэг, шинжилгээний дүгнэлтээр хэвийн гарсан, нас нь зорилтот насны сонголттой тохирч байгаа тохиолдолд үйлчлүүлэгчийг 3 жилийн дараа давтан Пап шинжилгээнд хамруулахаар дуудна гэдгийг мэдэгдэнэ.

**Эмгэг судлаач**

- Эдийн шинжилгээний хариу дүгнэлтийг Умайн хүзүүний эдийн шинжилгээний сорьцын **(СМУ-2/Эд)** цаасан маягтаар аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид мэдээлнэ.

**Эх барих, эмэгтэйчүүдийн эмч**

- Хавдар бүртгэгчээс эдийн шинжилгээний хариу дүгнэлт бүхий Умайн хүзүүний эдийн шинжилгээний сорьцын **(СМУ-2/Эд)** цаасан маягтыг хүлээн авна.
- Хэрэв ямар нэгэн арга хэмжээ авах ёстой бол үйлчлүүлэгчийн нэрийг хяналтад байлгах нэрсийн жагсаалтад үлдээж Өрх, сум тосгоны эмчээс шинээр ирэх **(АМ-13А)** маягттайгаар үйлчлүүлэгчийг ирэхийг хүлээнэ.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Эмгэг судлаачаас Умайн хүзүүний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМУ-2/Эд)**-ыг хүлээн авна.
- Дараа нь уг цаасан маягтыг Өрх, сум тосгоны эмч болон Эх барих, эмэгтэйчүүдийн эмчид илгээнэ.
- Эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлийн Умайн хүзүүний эдийн шинжилгээний сорьцын **(СМУ-2/Эд)** маягтын цахим хувилбарт цаасан маягт дээрх мэдээг оруулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Илрүүлгийн болон лабораторийн маягтуудыг бүртгэнэ.
- Хэрэв өмнө оношлогдсон тухай мэдээлсэн байвал хавдрын үндэсний бүртгэлд мэдээлнэ.

**Хавдрын үндэсний бүртгэл**

- Эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эс судлаач, эмгэг судлаач болон Өрх, сум тосгоны эмчийн тодотгож өгсөн, хавдартай холбоотой мэдээллүүдийг цуглуулна.
- Хяналтад байлгах нэрсийн жагсаалтад үйлчлүүлэгчийн нэрийг оруулна (цаашид шаардагдах мэдээллийг идэвхитэйгээр бүртгэж авахын тулд)


5-р алхам
Хэрэв өмөн оношлогдвол: Хавдрын үндэсний бүртгэл (ХҮБ)-д мэдээлнэ
Үйлчлүүлэгч
Хавдар бүртгэгч
Өрх, сумын эмч
Эргэн дуудах тогтолцоо
Эмгэг судлаач (Эд зүй)
Эх барих, эмэгтэйчүүдийн эмч

## 6-р алхам: Эмчилгээнд хамруулах

**Зорилго ба агуулга**

Үйлчлүүлэгч эмчилгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд Эх барих, эмэгтэйчүүдийн эмч хаана, яаж эмчилгээ хийх талаар үйлчлүүлэгчийг чиглүүлж өгнө. Тийм учраас Эх барих, эмэгтэйчүүдийн эмч энэ алхамын бүхий л үйл ажиллагааг хариуцах үүрэгтэй.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Эх барих, эмэгтэйчүүдийн эмч**

- Тухайн үйлчлүүлэгчид эмчилгээ хийхээр шийдсэн бол эмчилгээг өөрөө хариуцан хийнэ.
- Өөрөө эмчилгээ хийхээргүй бол, үйлчлүүлэгчийг эмчилгээ шаардлагатай дараагийн шатлалуудад (аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн хавдар судлаач эмч эсвэл ХСҮТ) шилжүүлнэ.
- Удирдамжид заасан арга хэмжээний аль тохирохыг авч хэрэгжүүлсэн эсэхээ илрүүлгийн маягт **(СМУ-2)**-аар аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид мэдээлнэ.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Илрүүлгийн маягтаар бүртгэгдсэн мэдээг эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд оруулна.
- Эргэн дуудах тогтолцооноос өгсөн сэрэмжлүүлгийг Эх барих, эмэгтэйчүүдийн эмч болон Өрх, сум тосгоны эмчид сануулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Эх барих, эмэгтэйчүүдийн эмчээс илрүүлгийн маягтуудыг (хавдар бүртгэгчээр дамжуулан) хүлээн авна.
- Эмгэг судлаач эмчийн дүгнэлтээр эмгэг өөрчлөлттэй эсвэл үзлэгээр нүдээр харагдахуйц эмгэг өөрчлөлт илэрсэн тохиолдолд эмчилгээнд хамруулна. Эх барих, эмэгтэйчүүдийн эмчээс ямар нэгэн "арга хэмжээ" авсан тухай мэдээ 4 долоо хоногийн дотор ирээгүй тохиолдолд тухайн аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид цахим сануулга автоматаар илгээгдэнэ.
- Эх барих, эмэгтэйчүүдийн эмчээс дахин 4 долоо хоногийн хугацаа өнгөрөхөд ямар нэгэн мэдээ, тайлан ирэхгүй байгаа тохиолдолд эхний сануулга өгнө, дараа нь мөн адил мэдээ хүлээн авахгүй бол 2 дахь сануулга мөн автоматаар илгээгдэнэ.



**Санамж**

- Дээрх хуудсанд оруулсан зурагт үзүүлсэнээр, үйлчлүүлэгч илрүүлэг үзлэгт хамрагдсаны дунд эцсийн дүгнэлт нь "Хэвийн" гарсан тохиолдолд илрүүлэг дуусгавар болно. Илрүүлгийн хүрээнд хийгдсэн умайн хүзүүний үзлэг, шинжилгээгээр Та хэвийн, эрүүл гарсан байна. Харин 3 жилийн дараа таны насилрүүлгийн үзлэгт хамрагдах наснаас хэтрээгүй бол дахин үзлэгт хамрагдаж, Пап шинжилгээг давтан хийлгэхээр таныг эргэн дуудах болно гэдгийг мэдэгдэнэ.
- Нөгөө талаас, үйлчлүүлэгч эмчилгээнд хамрагдсан тохиолдолд илрүүлгийн бүлэгт харьяалагдахгүй, цаашдын хяналтад хамрагдах болно. Иймээс үйлчлүүлэгчийн мэдээлэл цаашид эргэн дуудах тогтолцооны бүртгэлд бус, байнгын хэрэглэгддэг бусад эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоонд (Health Info, Canreg) хамаарна.
- Үйлчлүүлэгч хорт хавдраар өвчилсөн нь оношлогдож, эмчилгээнд хамрагдаж эхэлсэн үеэс илрүүлэг дуусгавар болох ба цаашдын нэмэлт мэдээллийг Эргэн дуудах тогтолцооны програмд оруулахгүй. Иргэний бүртгэл мэдээлэл /амьдарсан хугацааг үнэлэх/, Хавдрын үндэсний бүртгэл болон эргэн дуудах тогтолцоо зэрэг бүртгэлийн тогтолцоонууд харилцан холбоотой байснаар дараагийн алхамуудаас гарах мэдээлэл, үр дүнг илрүүлгийн үйл ажиллагааны явцтай холбож, үнэлэхэд хэрэглэнэ.

## ХӨХНИЙ ӨМӨНГИЙН БОЛОМЖИТ ИЛРҮҮЛЭГ

### *1-р алхам: Хөхний эмнэл зүйн үзлэг - Өрх, сум тосгоны эмч*

**Зорилго ба агуулга**

Хөхний өмөнг эрт үе шатанд нь илрүүлэхийн тулд дараах хоёр арга хэмжээг авсан байвал зохино. Нэгдүгээрт, үйлчлүүлэгч бүр хөхөө өөрөө шинжих аргаар хөхөө шинжсэн байна. Хоёрдугаарт, Өрх, сум тосгоны эмчид ямар нэгэн шалтгаанаар хандсан 30-60 насны бүх эмэгтэйчүүдэд хөхний эмнэлзүйн үзлэгийг жилд нэгээс доошгүй удаа хийж гүйцэтгэнэ. Мөн бүх эмэгтэйчүүдээс түүний наснаас үл хамааран, энэхүү үзлэгт хамрагдвал зохино гэдгийг сануулна. Өрх, сум болон багийн эмч, өрхийн сувилагч, эх баригч болон ХЭҮ хийх арга барилд суралцсан бусад эмнэлгийн мэргэжилтнүүд энэ үзлэгийг хийж, үйлчлүүлэгчид зөвлөгөө өгнө.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Өрх, сум тосгоны эмч (эсвэл бусад сургагдсан эмнэлгийн ажилтан)**

- Хөхний эмнэлзүйн үзлэгийг хийж гүйцэтгэнэ.
- Өрх, сум болон багийн эмчийн хөтлөх Хөхний эмнэлзүйн үзлэгийн цаасан маягт **(СМХ-1)**-ыг бөглөөд аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид илгээнэ.
- Хөхний талаас эмгэг өөрчлөлт илэрсэн буюу хариу эерэг гарсан тохиолдолд үйлчлүүлэгчийг мэс заслын эмчид, Эмнэлэгт өвчтөн илгээх маягт **(АМ-13А)**-ын хамт илгээнэ. Үүний өмнө үйлчлүүлэгчид цаашдын нэмэлт оношлогоо, шинжилгээ хийлгэхийн тулд яаралтай мэс заслын эмчид хандах хэрэгтэй болсныг мэдэгдэнэ.
- Хэрэв үйлчлүүлэгч дараагийн шатлалд үзлэг, шинжилгээнд хамрагдсан бол мэс засалч эмчид хандсанаас хойш 2 долоо хоногийн дараа үзлэг, шинжилгээний хариу, цаашдын зөвлөгөө зааврыг авахын тулд Өрх, сум тосгоны эмчид эргэн ирэх шаардлагатайг сануулна.
- Өндөр эрсдэлтэй бүлгийн илрүүлэг үзлэгт хамруулахаар дуудаж байгаа тохиолдолд үйлчлүүлэгчид мэдэгдэхээс гадна ХСҮТ-д бас мэдээлнэ, мөн цаашид хийгдэх шаардлагатай үзлэг, шинжилгээнд хамруулахаар үйлчлүүлэгчийг эргэн дуудна. Өндөр эрсдэлтэй бүлэгт хамруулах шалтгаан нь хөхний өмөнгөөр урьд нь өвдөж байсан, нэгдүгээр зэргийн садан төрөл нь (ээж, эгч болон охин дүү) хөхний өмөнгөөр өвдсөн дурьдатгалтай байх зэрэг болно.
- Аймаг, дүүргийн хавдар бүртгэгчээс өгсөн сануулгыг хүлээн авч, ямар арга хэмжээ авсан талаар цаасан байдлаар эргэн баталгаажуулна.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Илрүүлгийн цаасан маягтуудын мэдээг эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд оруулна.
- Тухайн орон нутгийн Өрх, сум тосгоны эмчид зориулан эргэн дуудах тогтолцооноос цахим болон цаасан байдлаар сануулга илгээнэ.
- Тухайн орон нутгийн Өрх, сум тосгоны эмчээс сануулгын хариуд өгсөн цаасан баталгааг эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд оруулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Маягтуудыг бүртгэнэ.
- Хэрэв үзлэг, шинжилгээгээр хавдар мэдээлэгдсэн байвал хавдрын үндэсний бүртгэлд мэдээлнэ.
- Эмгэг өөрчлөлт илэрснээс, цаашид мэс заслын эмчид үзүүлэх шаардлагатай боловч мэс заслын эмчээс 4 долоо хоногийн дотор хариу мэдээ бүртгэгдэхгүй бол Эргэн дуудах тогтолцооноос тухайн аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид автоматаар цахим сануулга илгээгдэнэ.
- Эхний сануулгын хүрээнд мэс засалч эмчээс дахин 4 долоо хоногийн хугацаанд ямар ч хариу мэдээ ирэхгүй бол 2 дахь сануулга автоматаар илгээгдэнэ.

**Хавдрын үндэсний бүртгэл**

- Үйлчлүүлэгчийн өөрийнх нь болон удмын дурьдатгалаас Хөхний өмөнгөөр өвдөх өндөр эрсдэлтэй болох нь тогтоогдсон бол өндөр эрсдэлтэй бүлгийн илрүүлгийг бүртгэх хэсгийн алхам 1.2-ыг баримтална.
- Эмнэлзүйгээр хавдрын сэжигтэй гарсан тохиолдолд Өрх, сум тосгоны эмчээс холбогдох мэдээллийг цуглуулна.
- Үйлчлүүлэгчийг цаашид хяналтад байлгах хүмүүсийн нэрсийн жагсаалтад оруулна (цаашид үзлэг, шинжилгээнээс гарах нэмэлт мэдээллүүдийг сайтар бүртгэж авна)


Алхам 1
Хавдар бүртгэгч
Хэрэв өмөн оношлогдсон бол ХҮБ-д мэдээлнэ
Өрх, сумын эмч
Эргэн дуудах тогтолцоо
Үйлчлүүлэгч
АНХААРУУЛГА !!!

## 2-р алхам: Соруулан авсан эсийн шинжилгээ

**Зорилго ба агуулга**

Хөхний эмнэлзүйн үзлэгээр сэжигтэй тохиолдол илэрсэн үед мэс заслын эмчид илгээж, хөхийг шинжүүлэх бөгөөд хөхнөөс эдээс дээж соруулан шинжилж, хорт хавдар байгаа эсвэл байхгүйг эсүйн оношоор баталж, цаашдын эмчилгээ, хяналтын асуудлыг шийдвэрлэнэ.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Мэс заслын эмч**

- Мэс заслын эмч хөхний эмнэлзүйн үзлэгийг удирдамжид заасны дагуу хийнэ.
- Үзлэгээр бэрсүү, үүсгэвэр тодорхойлогдвол хөхнөөс эсийн шинжилгээ авна.
- Хөхний эсийн шинжилгээний **(СМХ-2/Эс)** маягтын хамт соруулж авсан сорьцыг эс судлалын лабораторид илгээнэ.
- Мэс заслын эмч Хөхний эсийн шинжилгээний **(СМХ-2/Эс)** маягтаар ирсэн шинжилгээний хариуг хавдар бүртгэгч эмчээс хүлээн авч, эрт илрүүлгийн **(СМХ-2)** маягтыг хөтлөөд цаасаар аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид илгээнэ.
- Хоёр долоо хоногийн дараа шинжилгээний хариуг өрх, сум тосгоны эмчээсээ авахыг үйлчлүүлэгчид мэдэгдэнэ.

**Эс судлаач эмч**

- Хөхний эсийн шинжилгээний **(СМХ-2/Эс)** маягт болон сорьцыг хүлээн авч бүртгэнэ.
- Удирдамжийн дагуу сорьцод боловсруулалт хийж, дүгнэлт өгнө.
- Шинжилгээний хариуг Хөхний эсийн шинжилгээний **(СМХ-2/Эс)** маягтаар аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид илгээнэ.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Шинжилгээний хариуг Хөхний эсийн шинжилгээний **(СМХ-2/Эс)** маягтаар хүлээн авч мэс заслын эмчид илгээнэ.
- Цаасан маягтад бичсэн мэдээллийг эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд оруулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Маягтуудыг бүртгэнэ.
- Эс судлалын шинжилгээгээр хорт хавдар гэдэг нь тогтоогдсон бол хавдрын үндэсний бүртгэлд мэдээлнэ.

**Хавдрын үндэсний бүртгэл**

- Өрх, эмэгтэйчүүд, эс судлаач эмч нараас хорт хавдартай холбогдох мэдээллээс хайж лавлана.
- Хорт хавдар илэрсэн тохиолдолд өвчтнийг хяналтын жагсаалтад бүртгэнэ (цаашдын мэдээллийг идэвхитэй бүртгэхийн тулд)



## Алхам 3: Эсийн шинжилгээний үр дүнг мэдээлэх

### Зорилго ба агуулга

Хөхний эсийн шинжилгээний дүгнэлтээс хамаарч авах арга хэмжээ ба тусламж үзүүлэх хүмүүсийн хариуцах ажлыг энэ алхамд тодорхойлно.

### Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд

**Өрх, сум тосгоны эмч**

- Эсийн шинжилгээний хариуг хүлээж авна.
- Мэс заслын эмчид үзүүлээд буцаж ирсний дараа дахин өрх, сум тосгоны эмчдээ ирж үзүүлээрэй гэдгийг үйлчлүүлэгчид мэдэгдэнэ.
- Үзлэгээр хөхний талаас эмгэг илрээгүй тохиолдолд нэг жилийн дараа хөхний эмнэлзүйн үзлэгт орохыг зөвлөнө. Гэхдээ тэр болтол хөхөө өөрөө шинжих аргыг хэрэглэхийг зөвлөж, зааж өгнө.
- Хөхний талаас эмгэг илэрсэн тохиолдолд мэс заслын эмчид дахин үзүүлэхээр шилжүүлнэ.
- Эс судлалын шинжилгээний хариу (Хөхний эсийн шинжилгээний маягт **(СМХ-2/Эс)**-аар) гарсны дараа, өвчтөн нэг долоо хоногийн дотор ирж үзүүлэхгүй бол өрхийн сувилагч эсвэл бага эмч, сайн дурын ажилтны аль нэгээр дамжуулан, Өрх, сум тосгоны эмчид ирэхийг мэдэгдэнэ.

**Эс судлаач**

- Эсийн будагдсан сорьцыг бичил харуураар харж шинжилнэ.
- Сорьцын шинжилгээний дүнг (Хөхний эсийн шинжилгээний маягт **(СМХ-2/Эс)**-аар) цаасаар аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид илгээнэ.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Сорьцын шинжилгээний дүнг (Хөхний эсийн шинжилгээний **(СМХ-2/Эс)** маягтаар) цаасаар хүлээн авч мэс заслын эмчид илгээнэ.
- Хөхний эсийн шинжилгээний **(СМХ-2/Эс)** маягтаар цаасаар Өрх, сум тосгоны эмчид мэдээлнэ.
- Сорьцын шинжилгээний хариуг Хөхний эсийн шинжилгээний **(СМХ-2/Эс)** маягтаар эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд оруулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Маягт дахь мэдээллийг бүртгээд өмнө нь хүлээж авсан маягт дахь мэдээлэлтэй уялдуулан давхардал байгаа эсэхийг магадлана
- Хорт хавдар илэрсэн тохиолдолд Хавдрын Үндэсний Бүртгэлд мэдээлнэ.

**Хавдрын үндэсний бүртгэл**

- Хэрэв анхаарал татсан бол эс судлаач, мэс заслын эмч, Өрх, сум тосгоны эмч нараас хавдартай холбогдох мэдээллийг лавлана.
- Өвчтнийг хяналтын жагсаалтад бүртгэнэ (цаашдын мэдээллийг идэвхитэй бүртгэхийн тулд).



### Алхам 4: Мэс заслын эмчийн хийх цаашдын үнэлгээ, шинжилгээ

**Зорилго ба агуулга**

Хөхний эсийн шинжилгээгээр тогтоосон, сэжигтэй ямарч тохиолдлыг удирдамжийн дагуу хянаж, өмөншил байгаа эсэхийг батлах, цаашдын эмчилгээ болон хяналтыг хийх ёстой.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Мэс заслын эмч**

- Дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх ажлыг удирдамжид заасны дагуу хийнэ (эмнэлзүйн маммографи, хэт авиан шинжилгээ, эмгэг судлал/ эд зүйн шинжилгээ).
- Шинжилгээний сорьцыг эмгэг судлаачид (биопси авсан тохиолдолд), Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМХ-2/Эд)**-ын хамт илгээнэ.
- Мэс заслын эмч илрүүлгийн **(СМ-Х-2)** маягтыг ("Авсан арга хэмжээ") бөглөн цаасаар хавдар бүртгэгчид илгээнэ.
- Сорьцын шинжилгээний хариуг авахын тулд хоёр долоо хоногийн дараа өрх, сум тосгоны эмчдээ эргэн ирэхийг үйлчлүүлэгчид зөвлөнө.

**Аймаг, дүүргийн Хавдар бүртгэгч**

- Цаасаар ирсэн мэдээллийг эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд оруулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Маягтууд дахь мэдээллийг бүртгэнэ.
- Хорт хавдар мэдээлэгдсэн тохиолдолд Хавдрын үндэсний бүртгэлд автоматаар мэдээлнэ.

**Хавдрын үндэсний бүртгэл**

- Анхаарал татсан тохиолдолд мэс засал, эс судлаач, эмгэг судлаач, маммографи, хэт авианы эмч, өрхийн эмч нараас хавдартай холбогдох мэдээллийг цуглуулна.
- Өвчтнийг хяналтын жагсаалтад бүртгэнэ (цаашдын мэдээллийг идэвхтэй бүртгэхийн тулд)



## Алхам 5: Өрх, сум тосгоны эмч үзлэг, шинжилгээний дүгнэлтийг цуглуулах

**Зорилго ба агуулга**

Нэмэлт мэдээллүүдийг нэгтгээд шаардлагатай бол үйлчлүүлэгчийг эмчилгээнд дараагийн шатлалд шилжүүлнэ.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Өрх, сум тосгоны эмч**

- Сорьцын шинжилгээний хариуг хүлээж авна.
- Мэс заслын эмчид үзүүлсний дараа эргэж өрхийн эмчдээ үзүүлээрэй гэдгийг өвчтөнд мэдэгдэнэ.
- Шинжилгээний хариу хэвийн гарвал нэг жилийн дараа хөхний эмнэлзүйн үзлэг хийлгэхээр ирэхийг зөвлөнө. Дараагийн эрт илрүүлэг үзлэг хүртэл хөхөө өөрөө шинжих аргыг хэрэглэхийг зөвлөн зааж өгнө. Шинжилгээний хариу эерэг гарсан /эмгэгтэй/ тохиолдолд өвчтнийг яаралтай мэс заслын эмчид шилжүүлнэ.
- Эмгэг судлаач (Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМХ-2/Эд)**) эсвэл рентген, хэт авианы эмчээс Маммографи шинжилгээний маягт **(СМХ-3)** шинжилгээний дүгнэлтээр эерэг хариу гарсан тохиолдолд үйлчлүүлэгч нэг долоо хоногийн дотор ирж хариугаа хүлээн авахгүй бол өрхийн сувилагч, багийн бага эмч, эрүүл мэндийн сайн дурын ажилтны аль нэгээр дамжуулан өрхийн эмчид ирж үзүүлэхийг өвчтөнд мэдэгдэнэ.

**Эмгэг судлаач**

- Эдийн сорьцыг бичил харуурын шинжилгээнд бэлтгэнэ.
- Шинжилгээний хариуг Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМХ-2/Эд)**-д бичиж, цаасаар хавдар бүртгэгчид илгээнэ.

**Рентген/ дүрс оношлогооны эмч**

- Маммограммын зургийг уншиж, дүгнэлт өгнө.
- Шинжилгээний хариуг СМХ-3 маягтад бичиж цаасаар хавдар бүртгэгчид илгээнэ.

**Мэс заслын эмч**

- Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМХ-2/Эд)** ба **(СМХ-3)** маягтыг хавдар бүртгэгчээс хүлээн авна.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМХ-2/Эд)** ба **(СМХ-3)** маягтыг мэс заслын эмчид цаасаар илгээнэ.
- Өрхийн эмчид Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМХ-2/Эд)** болон СМХ-3 маягтыг цаасаар мэдээлнэ.
- Эдгээр маягт дахь үзлэг, шинжилгээний хариуг эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд оруулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Маягтууд дахь мэдээллийг бүртгээд өмнө нь хүлээж авсан маягтуудын мэдээлэлтэй холбож давхардлыг магадлана.
- Хорт хавдар тогтоогдсон тохиолдолд хавдрын Үндэсний бүртгэлд автоматаар мэдээлэгдэнэ.

**Хавдрын үндэсний бүртгэл**

- Шаардлагатай бол өрхийн болон мэс заслын эмч, эс судлаач эмчээс хавдартай холбогдох мэдээллийг цуглуулах.
- Хорт хавдар оношлогдсон тохиолдолд хяналтын жагсаалтад өвчтнийг бүртгэнэ (цаашдын мэдээллийг идэвхитэй бүртгэхийн тулд).


Алхам 5
Хэрэв өмөн оношлогдвол ХҮБ-д мэдээлнэ
Үйлчлүүлэгч
Цаашид тусламж, үйлчилгээ шаардлагатай болсон тохиолдолд мэс заслын эмчид очихыг үйлчлүүлэгчид мэдэгдэнэ
Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт (СМХ-2/Эд) цаасан (СМХ-3 цаасан)
Өрх, сумын эмч
Хавдар бүртгэгч
Эргэн дуудах тогтолцоо
Мэс заслын эмч
(СМХ-3 цаасан)
Эмгэг судлаач
Дүрс оношилгооны эмч (Маммографи,ЭХО...)

## Алхам 6: Эмнэлэгт хэвтүүлж эмчлэх

**Зорилго ба агуулга**

Эмчилгээ шаардлагатай бол хөхний хавдрыг эмчлэх талаар сургагдсан мэс заслын эмч эмчилгээг хийнэ. Ийм учраас энэ алхамын хүрээнд хийгдэх ажлыг мэс заслын эмч хариуцна. Хөхний өмөнгийн мэс заслын эмчилгээг ХСҮТ-д хийх ёстой.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Мэс заслын эмч**

- Өвчтнийг ХСҮТ-д шилжүүлнэ.
- Удирдамжид заасны дагуу **(СМХ-2)** маягтаар аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид ямар арга хэмжээ авсан талаар мэдээлнэ.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд **(СМХ-2)** цаасан маягтын мэдээллийг оруулна.
- Эргэн дуудах тогтолцооны програмын зүгээс сануулга ирсэн тохиолдолд мэс заслын эмч ба өрхийн эмчид сануулгыг дамжуулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Мэс заслын эмчээс **(СМХ-2)** маягтаар мэдээллийг авна (хавдар бүртгэгчээр дамжуулан).
- Ийм мэдээлэл аль нэг түвшинд бүртгэгдсэн бол эмчилгээнд илгээх ёстой бөгөөд дөрвөн долоо хоногийн дотор мэс заслын эмчээс арга хэмжээ авсан эсвэл эмчилгээ хийсэн талаар мэдээлэл ирэхгүй бол холбогдох аймгийн хавдрын бүртгэлийн ажилтанд цахим хуудсаар автоматаар сануулга илгээнэ.
- Анхдагч сануулгаас хойш дахин дөрвөн долоо хоногийн хугацаанд мэс заслын эмчээс мэдээ орж ирэхгүй бол хоёрдахь сануулгыг автоматаар илгээнэ.



**Санамж**

- Дээрх хуудаснуудад дурьдсан ажилбарыг өвчтөн хийлгээд, шинжилгээний эцсийн үр дүн хэвийн гарсанаар илрүүлэг дуусгавар болно. Илрүүлгийн үзлэг, шинжилгээгээр хэвийн байгаа тухай өвчтөнд мэдэгдэж, сар тутам хөхөө өөрөө шинжиж байх, мөн нэг жилийн дараа хөхний эмнэлзүйн шинжилгээнд хамрагдахыг зөвлөнө.
- Хэрэв өвчтөн хөхний өмөнгийн улмаас эмчилгээ хийлгэхээр эмнэлэгт хэвтсэн бол цаашдаа уг эмэгтэй эрт илрүүлгийн бүлэгт хамрагдахгүй харин ХСК-ын хавдар судлаач эмчийн хяналтад байна. Энэ цагаас эхлэн тэрээр эргэн дуудах тогтолцооны бүртгэлд бус харин эмнэлгийн хяналтын бүртгэлд байх ёстой (Health Info, Canreg...).
- Үйлчлүүлэгч хорт хавдраар өвчилсөн нь оношлогдож, эмчилгээ хийгдэж эхэлмэгц илрүүлгийн үйл ажиллагаа дуусгавар болно. Энэ үеэс эхлэн эргэн дуудах тогтолцоонд тухайн үйлчлүүлэгчийн талаархи нэмэлт мэдээлэл орохгүй, дараагийн алхамуудын мэдээлэл, үр дүн нь эргэн дуудах тогтолцоо, хавдрын үндэсний бүртгэл, хүн амын бүртгэл мэдээлэлтэй харилцан холбоотой байж, амьдарсан хугацааг тооцоход мэдээллийг нь хэрэглэнэ.

# ХӨХНИЙ ӨМӨНГӨӨР ӨВДӨХ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ БҮЛГИЙН ИЛРҮҮЛЭГ

## Алхам 1: Хөхний өмөнгөөр өвдөх өндөр эрсдэлтэй бүлгийн үйлчлүүлэгчийг олж тогтоох

*Алхам 1.1: Өрх, сумын эмчийн үүрэг*

### Зорилго ба агуулга

Урьд нь хөхний өмөнгөөр өвдөж эмчлүүлж байсан, эсвэл ойрын төрөл садан (ээж, эгч, охин дүү) нь хөхний өмөнгөөр өвдөж байсан дурьдатгалтай эмэгтэй бүр хөхний өмөнгөөр өвдөх өндөр эрсдэлтэйд тооцогдох ба тогтмол илрүүлгийн хүрээнд маммографи, хөхний эмнэлзүйн үзлэг, шаардлагатай үед соруулах аргаар авсан эдийн шинжилгээ (гурван шатлалт үнэлгээ)-нд жил тутам хамрагдах ёстой. Өрх, сумын эмч эдгээр эмэгтэйчүүдийг олж тогтоон, хөхний эмнэлзүйн үзлэгт хамруулж СМ-Х-1 маягтыг бөглөх үүрэгтэй бөгөөд энэ маягтад хувь хүний болон гэр бүлийн дурьдатгал бүртгэгдсэн байх ёстой.

### Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд

**Өрх, сумын эмч**

- Өвчний болон гэр бүлийн дурьдатгалыг асууж **(СМХ-1)** маягтад бичнэ.
- Хөхний эмнэлзүйн үзлэгийг хийж **(СМХ-1)** маягтыг бөглөж аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид илгээнэ.
- (Боломжит илрүүлгийн бүлгийг үзнэ үү) Шинжилгээний дүн зэрэг гарч эмгэг илэрсэн эсвэл удмын дурьдатгал илэрсэн тохиолдолд өвчтнийг мэс заслын эмчид шилжүүлнэ.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- **(СМХ-1)** маягтын мэдээллийг цахим бүртгэлд оруулна.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Тухайн өвчтөн урьд нь хөхний өмөнгөөр өвдөж эмчлүүлж байсан мэдээлэл байгаа эсэхийг хавдрын үндэсний бүртгэлийн хяналтын мэдээний сан (Health Info, Canreg)-гаас магадлана.
- Өрхийн эмчийн хөтлөх **(СМХ-1)** маягт дээр хөхний өмөнгөөр өвдөж байсан ойрын садан төрлийнх нь овог нэр, регистрийн дугаарыг оруулж, энэ мэдээллээр хайсны дүнд эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдийн нэрсийн жагсаалтыг гаргана.



*Алхам 1.2: Хавдрын үндэсний бүртгэлийн үүрэг- идэвхитэй эрэн хайх*

**Зорилго ба агуулга**

Урьд нь хөхний өмөнгөөр өвдөж эмчлүүлж байсан, ойрын төрөл садан (ээж, эгч, охин дүү) нь хөхний өмөнгөөр өвдөж байсан дурьдатгалтай эмэгтэй бүр тогтмол илрүүлгийн хүрээнд маммографи, хөхний эмнэлзүйн үзлэг, шаардлагатай үед эд соруулах шинжилгээ (гурван шатлалт үнэлгээ)-нд жил тутам хамрагдах ёстой. Хавдрын үндэсний бүртгэл нь ойрын төрөл садан эмэгтэй нь хөхний өмөнгөөр өвдөж байсан дурьдатгалтай эсвэл урьд нь хөхний өмөнгөөр өвдөж, эмчлүүлж байсан эмэгтэйн талаархи мэдээллийг Хавдрын үндэсний бүртгэлийн програмаас идэвхитэй эрж хайх замаар илрүүлэн мэдээлнэ.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Хавдрын үндэсний бүртгэл**

- Хөхний өмөнгөөр өвдөж, эмчлүүлж байсан эмэгтэйг эргэн дуудах тогтолцооны болон ХҮБ-ийн хяналтаас эрж хайна.
- Эмчилгээний дараа амьд байгаа эсэхийг магадлан, тэдний хаягийг тогтооно.
- Эргэн дуудах тогтолцооноос илрүүлсэн эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдийн нэрсийн жагсаалтаас, хөхний өмөнгөөр өвдөж байсан дурьдатгалаас ойрын төрөл садан (ээж, эгч, охин дүү) эмэгтэйн хаягийг олж тогтооно.
- Илрүүлсэн тохиолдлуудыг эргэн дуудах тогтолцоонд мэдээлнэ.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Мэдээ, тайланг хүлээн авна.
- Өрхийн эмчийн хөтлөх **(СМХ-1)** маягт дээрх садан төрлийн мэдээлэл дээр үндэслэн гаргасан мэдээллийн дагуу хайлт хийнэ.



Алхам 2: Өндөр эрсдэлтэй бүлэгт хамрагдах үйлчлүүлэгчийг дуудах

**Зорилго ба агуулга**

Өндөр эрсдэлтэй бүлэгт хамрагдах үйлчлүүлэгчийг олж тогтоогоод, жил бүр гурван шатлалт илрүүлэг үзлэгт хамруулна. Энэ үзлэгийг БОЭТ ба ХСҮТ-д хөхний үзлэгийг хариуцсан мэргэжлийн эмч нар хийнэ.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Тухайн аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид цахим бүртгэлд суурилсан өвчтний нэрсийн жагсаалтыг илгээнэ (өвчтөнд аль ойр байгаа БОЭТ ба ХСҮТ-д).

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Цаасан дээр хэвлэсэн нэрсийн жагсаалтыг холбогдох өрхийн эмчид илгээнэ.

**Өрх, сумын эмч**

- Өрхийн эмч эргэн дуудах тогтолцооны програмаас өгсөн сануулгын дагуу өвчтнийг өрхийн сувилагч, бага эмч, сайн дурын ажилтны аль нэгээр дуудуулна.
- Аль ойр байгаа БОЭТ эсвэл ХСҮТ-д маммографийн шинжилгээ хийлгэхийг өвчтөнд зөвлөн, эмнэлэгт өвчтөн илгээх хуудсын **(АМ-13А)** хамт илгээнэ.



## Алхам 3: Илрүүлэг

Алхам 3.1: Маммографийн шинжилгээгээр илрүүлэг хийх

**Зорилго ба агуулга**

Энэ алхамын хүрээнд хийх ажлыг БОЭТ-д эсвэл ХСҮТ-д хийнэ.
Үүний тулд "нэг цэгээс" үйлчлэх зарчмыг баримтална. Энэ нь үйлчлүүлэгч тухайн төвд ирээд 1 өдрийн дотор шинжилгээ хийлгэж, хариуг нь авч, мэдээлэл, зөвлөгөөг бүрэн аваад буцна гэсэн үг юм. Энэ үйл ажиллагаа маммографи хийлгэхээс эхлэнэ.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Рентгений /дүрс оношилгооны/ эмч**

- Маммографийн шинжилгээ хийж, дүгнэлт өгнө.
- Маммограммыг зайн телемедицины цахим хуудсаар дамжуулан ХСҮТ-д илгээж, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчээр хянуулан дүгнэлт гаргуулж болно.
- **(СМХ-3)** маягтаар хавдар бүртгэгчид мэдээлнэ.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- **(СМХ-3)** маягтын мэдээллийг эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд оруулна.
- **(СМХ-3)** маягтыг мэс заслын эмч /хавдрын эмч/-д илгээнэ.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- **(СМХ-3)** маягтын мэдээллийг аймаг, дүүргийн хавдар бүртгэгч нараас цуглуулна.

**Мэс заслын эмч**

- Өвчтөн мэс заслын эмч /хавдрын эмч/-д ирэхэд, маммографийн шинжилгээний хариу нь **(СМХ-3)** маягтаар ирсэн байх ёстой.

Алхам 3.1



*Алхам 3.2: Хөхний эмнэлзүйн үзлэг ба соруулах аргаар эдийн шинжилгээний сорьц авах*

**Зорилго ба агуулга**

Мэс заслын /хавдрын/ эмч хөхний эмнэлзүйн үзлэг хийсний дараа шаардлагатай гэж үзвэл соруулах аргаар эдийн шинжилгээний сорьц авна.

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Мэс заслын эмч**

- Маммограммын зургийн дүгнэлттэй танилцана.
- Хөхний эмнэлзүйн үзлэг хийнэ.
- Шинжилгээний болон үзлэгийн дүн эерэг гарсан тохиолдолд соруулах аргаар эдийн сорьц авна (шаардлагатай гэж үзвэл хөхний хэт авиан шинжилгээний хяналтын дор хийнэ).
- Эдийн шинжилгээний сорьцыг Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМХ-2/Эд)**-ын хамт эмгэг (эд) судлаач эмчид илгээнэ.
- **(СМХ-2)** маягтаар аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид мэдээлнэ.
- Аймаг, дүүргийн хавдар бүртгэгчээс илгээсэн эд судлалын шинжилгээний дүгнэлтийг Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМХ-2/Эд)**-аас харна.

**Аймаг, дүүргийн хавдар бүртгэгч**

- Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМХ-2/Эд)**-ын мэдээллийг эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд оруулна.
- Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМХ-2/Эд)**-ыг мэс заслын /хавдрын/ эмчид илгээнэ.

**Эмгэг судлаач**

- Будсан наацыг шинжилнэ.
- Шинжилгээний хариу бүхий Хөхний эдийн шинжилгээний сорьцын маягт **(СМХ-2/Эд)**-ыг аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид илгээнэ.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Мэдээллийг цуглуулна.
- Хорт хавдар оношлогдсон тохиолдолд хавдрын үндэсний бүртгэлд мэдээлнэ.



Алхам 4: Үйлчлүүлэгчийг эмнэлэгт эмчлүүлэхээр шилжүүлэх

| **Зорилго ба агуулга** |
|---|
| Эмчилгээ шаардлагатай бол үйлчлүүлэгчид холбогдох мэдээллийг өгсний дараа хэвтүүлэн эмчлэхэд шаардлагатай урьдчилсан бэлтгэлийг хийнэ. Хөхний хавдрын мэс заслын эмчилгээг зөвхөн ХСҮТ-д хийнэ. |

**Зорилтууд ба хийгдэх үүрэгт ажлууд**

**Мэс заслын /хавдрын/ эмч**

- Үйлчлүүлэгчийг Эмнэлэгт өвчтөн илгээх **(АМ-13А)** хуудсаар ХСҮТ-д шилжүүлнэ.
- Үйлчлүүлэгчид үзлэг, шинжилгээний үр дүнг мэдээлж, цаашид ямар арга хэмжээ авах талаар зөвлөгөө өгнө.
- Шинжилгээний хариу хэвийн бол нэг жилийн дараа дахин үзлэгт хамрагдахыг үйлчлүүлэгчид зөвлөнө.
- Удирдамжид заасны дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний талаархи мэдээллийг СМХ-2 маягтаар Эргэн дуудах тогтолцооны бүртгэлд мэдээлнэ.

**Эргэн дуудах тогтолцооны програм**

- Мэдээллийг хүлээн авна.
- Хавдрын үндэсний бүртгэлд мэдээлэгдсэн эсэхийг шалгана.



**Санамж**

- Дээр дурьдсан үзлэг шинжилгээ хийлгэсний дараа үр дүн нь хэвийн гарсан тохиолдолд илрүүлэг үзлэг дууснa. Илрүүлэг үзлэгт хамрагдсан эмэгтэйд бүх зүйл хэвийн байгаа тохиололд цаашид сар бүр хөхөө өөрөө шинжиж байхаас гадна нэг жилийн дараа дахин хөхний маммограф (рентген шинжилгээ) хийлгэхийг зөвлөнө.
- Хэрэв тухайн эмэгтэй хөхний өмөн эмчлүүлэхээр эмнэлэгт хэвтсэн бол илрүүлгийн бүлэгт хамрахгүй, харин эмнэлгийн байнгын хяналтад байна. Энэ цагаас эхлэн, эргэн дуудах тогтолцооны бүртгэлд нэмж мэдээлэл орохгүй, харин хавдрын үндэсний бүртгэлийн (Health Info, Canreg) хяналтын бүртгэлд байх болно.
- Цаашид хийгдэх эмнэлзүйн үзлэг, оношлогооны бүх арга хэмжээ нь илрүүлгийн бус, харин эмнэлгийн хяналтын үйл ажиллагаа байх болно.
- Хэт авиан шинжилгээ, эдийн шинжилгээнд сорьц авах зэрэг цаашид хийгдэх оношлогооны ажилбарууд нь илрүүлгийн хүрээнд хийгдэх ажилбарууд биш юм. Үйлчлүүлэгч хавдраар өвчилсөн нь оношлогдож, эмчилгээ хийж эхэлсэн үеэс эхлэн илрүүлгийн үе шат дуусгавар болно. Үүнээс хойш хийгдсэн ажилбаруудын тухай нэмэлт мэдээллийг эргэн дуудах тогтолцооны мэдээлэлд оруулахгүй. Дараагийн алхамуудын мэдээлэл ба үр дүн нь эргэн дуудах тогтолцоо, хавдрын үндэсний бүртгэл, иргэний бүртгэлийн мэдээлэлтэй харилцан уялдаатай байж, амьдарсан хугацааг тооцоход ач холбогдолтой.

## 9. Дүгнэлт, зөвлөмж

Энэ хэсэгт илрүүлгийн үйл ажиллагааны явцад хийгдэх хяналт, үнэлгээний чиглэлээр оруулсан дүгнэлт, зөвлөмжийг тусгасан болно.

***Зорилго***

Энэ удирдамж нь үндэсний хэмжээнд аливаа өвчин эмгэгийн илрүүлгийн бодлогод нийцэж байна уу гэдгийг батлах

**9.1 Үйл ажиллагааны заавар, журам**

***Зорилго***

Үндэсний хэмжээний бодлогын хүрээнд тухайн орон нутгийн үйл ажиллагааны заавар, журмын дагуу үйлдлүүд хийгдсэн байх

| Заавар, зөвлөмж | Эргэн шинэчлэх давтамж |
|---|---|
| Эмнэлгийн шатлал тус бүрт зориулсан, үйл ажиллагааг нь тодорхой тусгасан бодлогын баримт бичиг болсон байх | Жил бүр эргэн харах ба үндэсний бодлогын хүрээнд засвар, шинэчлэлтийг оруулах |

**9.2 Тогтолцооны үзүүлэлт/ мэргэжилтнүүдийн ажиллах журам**

| Заавар, зөвлөмж | Эргэн шинэчлэх давтамж |
|---|---|
| Эмнэлгийн шатлал тус бүрийн эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан байх | Тогтолцооны үйл ажиллагааны явцад явцын хяналт тавих |
| Эмнэлгийн ажилтан, мэргэжилтэн тус бүрийн гүйцэтгэх ажил үүргийг нэг бүрчлэн заан оруулах | Тогтолцооны үйл ажиллагааны явцад явцын хяналт тавих |
| Параклиник буюу лаборатори, дүрс оношилгооны эмч, мэргэжилтнүүдийн ажил, үүргийг заан оруулах | Тогтолцооны үйл ажиллагааны явцад явцын хяналт тавих |
| Үйлдэл, тухайн үйлдлийг хийсэн эзэн бүрт тохирсон үнэлгээ, хяналт хийгдэх | Хийгдэх ёстой үйлдлүүд хийгдсэн эсэхийг улирал бүр хянах |

**9.3 Бүх сонгогдсон эмэгтэй илрүүлэг үзлэгт хамрагдсан эсэхийг хянах**

***Үндэсний бодлого***

Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгт 30-60 насны эмэгтэйг 3 насны давтамжтайгаар (30, 33, 36 ...60 нас) сонгон хамруулна. Мөн жирэмсний эхний 3 сарын хугацаанд буй жирэмсэн эмэгтэйг хамруулна. Харин хөхний өмөнгийн илрүүлэгт ямар нэгэн шалтгаанаар эмнэлэгт хандсан эмэгтэй болон хөхний өмөнгөөр өвдөх өндөр эрсдэлтэй эмэгтэйг мөн нэмэлтээр хамруулна.

***Зорилго***

Илрүүлэг үзлэгт хамруулахаар сонгосон эмэгтэй бүр хамрагдсан болох, удирдамжид заасны дагуу эргэн дуудсан болохыг хянах

| **Заавар, зөвлөмж** | **Эргэн шинэчлэх давтамж** |
|---|---|
| Илрүүлэг үзлэгт хамруулахаар сонгосон эмэгтэй бүр хамрагдсан болох | Сар бүр хянаж, үнэлнэ |
| Эргэн дуудсан болохыг хянах | Сар бүр хянаж, үнэлнэ |
| Илрүүлэг эхлэхээс 1 сарын өмнө эмэгтэйд мэдэгдсэн байх | Тогтолцооны үйл ажиллагааны явцад явцын хяналт тавих |

**9.4 Сонгосон эмэгтэйг урих**

***Үндэсний бодлого***
Сонгогдсон бүх эмэгтэй умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгт хамрагдахыг урьсан бичгэн урилга, түүний ар талд ямар бэлтгэл хангах, мөн өөр шаардлагатай нэмэлт мэдээлэл бүхий зааварчилгааг хавсаргасан байна.

***Зорилго***
Эмэгтэйд цаг хугацаа нь тодорхой, ойлгомжтой бичсэн урилгыг хүргэх

| **Заавар, зөвлөмж** | **Эргэн шинэчлэх давтамж** |
|---|---|
| Сонгогдсон эмэгтэйн нэрсийн жагсаалтыг гаргах | Өрх, сум тосгоны эмнэлгийн бүртгэсэн Хүн амын мэдээлэл дээр үндэслэн сар бүр Эргэн дуудах тогтолцооны програмд илрүүлэгт хамрагдах хүн амын мэдээллийг нэгтгэнэ |
| Өрх, сум тосгоны эмч тухайн харьяа орон нутагтаа түр болон байнгын оршин суугаа иргэдийн бүртгэлийг идэвхитэй бүртгэх замаар эргэн шинэчлэх | Жилд 2 удаа |
| Илрүүлэг эхлэхээс 2 долоо хоногийн өмнө урилга өгсөн байдлыг хянах | Сар бүр |
| Урилга хүргэж чадаагүй эмэгтэйн нэрсийн жагсаалтыг гаргаж, илрүүлэг үзлэгт хамрагдах хугацааг хойшлуулах, дахин урилга илгээх эсвэл Эргэн дуудах тогтолцооны програмд мэдээлж хайлт хийлгэх | Сар бүр |

**9.5 Үйл ажиллагааны үр дүнг бүртгэх, мэдээлэх**

***Үндэсний бодлого***

Үйл ажиллагааны үр дүнг Эргэн дуудах тогтолцоонд мэдээлэх

***Зорилго***

Үр дүнг тогтоосон цаг хугацаанд нь үнэн зөв мэдээлэх

| Заавар, зөвлөмж | Эргэн шинэчлэх давтамж |
|---|---|
| Эргэн дуудах тогтолцооны програмын зүгээс аймаг, дүүргийн Хавдар бүртгэгч нарт илрүүлгийн мэдээг эргэн мэдээлэх | Сар бүр |
| Аймаг, дүүргийн эмнэлгүүд эс болон эмгэг судлалын лабораториудтайгаа цахим байдлаар холбогдсон байх | Тогтмол холбоотой байх |
| Лабораториос өгсөн хариу дүгнэлтэд ямар нэгэн засвар орсон байвал эргэн асууж сурвалжлах | Өдөр тутам |
| Эргэн дуудах тогтолцооноос лаборатори тус бүр рүү сар бүр хийгдсэн шинжилгээний наац, сорьцын тоо, мэдээллийг илгээх | Сар бүр |
| Эсийн шинжилгээний наацын хариу дүгнэлт хэдий хугацаанд гарч байгаа талаар хянах | Сар бүр |
| Эдийн шинжилгээний сорьцын хариу дүгнэлт хэдий хугацаанд гарч байгаа талаар хянах | Сар бүр |
| Умайн хүзүүний Пап шинжилгээнд хамрагдсан эмэгтэйчүүдийн дахин хамрагдалтын шалтгаан, хувь | Сар бүр |

**9.6 Үйл ажиллагааны үр дүнг мэдээлэх**

***Үндэсний бодлого***

Илрүүлэг үзлэгт хамрагдсан эмэгтэй бүрт үзлэг, шинжилгээний хариу дүгнэлтийг мэдээлнэ. Үзлэг, шинжилгээ хийгдсэн өдрөөс хойш 2 долоо хоногийн дараа гэхэд 80%-д, 4 долоо хоног гэхэд 100%-д нь хариу дүгнэлтийг мэдээлсэн байна.

***Зорилго***

Хариу дүгнэлтийг цаг хугацаанд нь, нягт нямбай мэдээлэх ажиллагааг нэвтрүүлэх

| Заавар, зөвлөмж | Эргэн шинэчлэх давтамж |
|---|---|
| Хариу, дүгнэлтийг илгээх мэргэжилтний үүрэг хариуцлагыг тодорхой оруулах | Жил бүр эргэн харах, шаардлагатай бол нэмэлт өөрчлөлт оруулах |
| Шинжилгээний хариуг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор үйлчлүүлэгчид мэдээлэх | Долоо хоног бүр үнэлнэ |
| Өрх, сумын эмчид илгээсэн цахим мэдээлэл эмч хүлээн аваагүйгээс шалтгаалан буцаж ирэх | Хүлээн авагдаагүй мэдээлэл буцаж ирэх |

**9.7 Зохистой байдлаар хянах ба эргэн дуудах**

***Үндэсний бодлого***

Үйлчлүүлэгч эмэгтэй шинжилгээний хариугаа хүлээн авч, эргэн дуудагдах арга хэмжээг аль болохоор зохистой байдлаар хэрэгжүүлэх

***Зорилго***

Үйлчлүүлэгчийг тогтсон цаг хугацаанд нь зохистой аргаар эргэн дуудах

| Заавар, зөвлөмж | Эргэн шинэчлэх давтамж |
|---|---|
| Хариу, дүгнэлтийг илгээх мэргэжилтний үүрэг хариуцлагыг хянах | 7 хоног бүр |
| Шинжилгээний хариуг үйлчлүүлэгчид хүргэсэн эсэхээ ажлын 5 өдрийн дотор Хавдар бүртгэгчид мэдээлэх | Ажлын 5 өдөрт багтаана |

**9.8 Мэдээний чанар**

***Зорилго***

Мэдээний чанарын шаардлагыг хангаж, эрсдлийг бууруулах

| Заавар, зөвлөмж | Эргэн шинэчлэх давтамж |
|---|---|
| Мэргэжилтнүүдийг сургах сургалтын хөтөлбөрт "Мэдээний чанар"-ын асуудлыг багтаах | Жил бүр эргэн харж, шинэчилнэ |
| Програмд аль болох чөлөөт үгэн байдлаар бичиж оруулах талбарыг оруулахгүй байх | |
| Илрүүлгийн маягтад буй нээлттэй хариулт бүхий чөлөөт үгэн байдлаар бичиж оруулах талбарыг програмд оруулахгүй байх | |
| Тэмдэглэл бичих талбарыг шалгаж, шаардлагагүй тэмдэглэл, бичиглэл байвал арилгах | Улирал бүр |
| Эргэн дуудах тогтолцооны цахим бүртгэлд мэдээлэл оруулсан мэргэжилтэн тус бүрээр хяналт тавих, шаардлагатай тохиолдолд сануулга өгөх | Тогтмол |

**9.9 Эмнэлгийн мэргэжилтний сургалт, чадавхийг бэхжүүлэх**

*Тавигдах шаардлага*

Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй илрүүлэг үзлэгт оролцож байгаа эмч, мэргэжилтнүүдийн цаашдын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд анхааран, дэмжиж ажиллана.

*Зорилго*

Хувь хүн ажлын байран дээрээ хөгжих, суралцах орчныг бүрдүүлэх

| Заавар, зөвлөмж | Эргэн шинэчлэх давтамж |
|---|---|
| Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй Хавдар бүртгэгч нь сургалтанд хамрагдаж, цаашид бусад мэргэжилтнүүдийг сургах | 6 сар - 1 жилийн хугацаанд |
| Илрүүлгийн үйл ажиллагаанд оролцож буй бүх эмч, мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх | Жил бүр эргэн шинэчилнэ |

**9.10 Мэдээний нууцлал, аюулгүй байдал**

***Тавигдах шаардлага***

Монгол улсын Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцооны нууцлал, аюулгүй ажиллагааны хүрээнд мөрдөгдөж буй бүхий л дүрэм, журмыг мөрдөн ажиллана. Илрүүлгийн үйл ажиллагаанд оролцож буй бүх эмч, мэргэжилтнүүдэд мэдээний нууцлал, аюулгүй ажиллагааны мөрдөн ажиллах журмыг таниулсан байх шаардлагатай.

***Зорилго***

Илрүүлгийн мэдээлэлтэй холбогдолтой ямар нэгэн байдлаар мэдээний нууц алдагдах байдлыг бүрэн хянаж, уг эрсдлийг гаргуулахгүй байх

| **Заавар, зөвлөмж** | **Эргэн шинэчлэх давтамж** |
|---|---|
| Эмнэлгийн шатлал тус бүрийн эмч, мэргэжилтнүүдэд програмд орох, танилцах мэдээлэлд тодорхой хязгаар тавих | 6 сар - 1 жилийн хугацаанд эргэн шинэчилнэ. Эмч, мэргэжилтний ажлын байр өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинэчилнэ |
| Эмч, мэргэжилтэн бүрт хувийн нууц код өгөх ба кодыг бусдад задруулснаас гарах аливаа хохирлыг уг мэргэжилтэн бүрэн хариуцах | Сар бүр кодыг шинэчилнэ, шаардлагатай тохиолдолд тухай бүр шинэчилнэ |
| Мэдээлэл гаргах, түгээх бол гэрээ хийх эсвэл ямар нэгэн баримт бичиг үйлдэж баталгаажуулах | |
| Монгол улсын Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцооны бүртгэлийн маягтууд хадгалах хугацааны хүрээнд хадгалах хугацааг заан оруулах | Гурван жил тутам эргэн үнэлж, шаардлагатай тохиолдолд эргэн шинэчилнэ |

**9.11 Эрсдлийн зохицуулга**

***Зорилго***

Бодлогын баримт бичиг болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэх үйл ажиллагааны явцад гарах эрсдлийг бууруулах, зохицуулах

| Заавар, зөвлөмж | Эргэн шинэчлэх давтамж |
|---|---|
| "Зөвхөн унших" буюу зөвхөн мэдээллийг харах, нэмэлт мэдээлэл, өөрчлөлт орохгүй байдлаар талбар оруулж өгөх | Жил бүр эргэн шинэчилнэ |
| Шатлал болон мэргэжилтнүүдийн ажил, үүргээс хамаараад мэдээлэл харах, оруулахад тодорхой хязгаартай байх | Жил бүр эргэн шинэчилнэ |
| Байнгын аудит хийх | Төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж, аудитаас гарсан дүгнэлтэд үндэслэн зөвлөмж өгөх |
| Сар бүр илрүүлгийн үйл ажиллагааны хэрэгжилтийн биелэлтийг гарган өгөх | Сар бүр |

**9.12 Илрүүлгийн бодлогын хэрэгжилтийг хянах -үнэлэх**

***Зорилго***

Илрүүлгийн үйл ажиллагааны биелэлтийг хянах -үнэлэх

| Заавар, зөвлөмж | Эргэн шинэчлэх давтамж |
|---|---|
| II шатлалд ажиллаж буй Хавдар бүртгэгчид үйл ажиллагааны биелэлтийг нь мэдээлэх | Сар бүр |
| Тодорхой тайлангийн маягт ашиглан биелэлтийг хянах -үнэлэх | Илрүүлгийн тайлангийн маягтыг жил бүр эргэн шинэчилнэ |

**Хавсралт 1. Умайн хүзүүний өмөнгийн илрүүлгийн маягтууд**

Эмнэлгийн нэр ______________

□□□□□□

ЭМСайдын 2010 оны 02 сарын 34 тоот
тушаалын нэмэлтээр батлав

## Хүн амын мэдээллийн шинэчилсэн бүртгэлийн хуудас

| № | Эцгийн нэр | Нэр | Регистрийн дугаар | Оршин суугаа хаяг | | Холбогдох утасны дугаар | Тулгалт хийсэн үр дүн | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хот, дүүрэг; аймаг, сумын нэр | Баг, хороо; гудамж, байрны дугаар | | Шилжиж ирсэн | Шилжиж явсан | Нас барсан | Сураггүй болсон |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |

Мэдээнд тулгалт хийж баталгаажуулсан: /............................../ /............................../ /............................................/
(Гарын үсэг) (Овог, нэр) (Албан тушаал)

Эрүүл мэндийн бүртгэлийн маягт
**АМ-1Д**

## УМАЙН ХҮЗҮҮ, ХӨХНИЙ ӨМӨНГИЙН ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН БҮРТГЭЛ

Эрүүл мэндийн байгууллагын нэр:_________
Эмчийн нэр:_________________________

**20...... оны ...... сар**

*Өрх, сум тосгоны эмч, эмэгтэйчүүдийн эмч, мэс заслын эмч, хавдрын эмч /зур/*

| № | Он, сар, өдөр | Эцэг/эх/-ийн нэр, Нэр Регистрийн дугаар | Нас | Тогтмол хаяг ЭМД-ын дугаар | Ажлын газар, холбоо барих утасны дугаар | Өр, сумын эрүүл мэндийн төв | | | | | | | | Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн ЭМН | | | | Онош /ӨОУА-10/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үзлэгийн хэлбэр | | | | | | Шинжилгээнд илгээсэн | | | | Хийгдсэн эмчилгээ | | |
| | | | | | | Умайн хүзүүний өмөнгийн илрүүлэг | | Хөхний өмөнгийн илрүүлэг | | Хөхний өмөнгийн өндөр эрсдэлт бүлгийн илрүүлэг | | Пап наац | | АМ13А маягтаар ирсэн | Эдийн шинжил-гээний сорьц илгээсэн | Эмийн эмчилгээ | Мэс ажилбар | |
| | | | | | | Анх | Давтан | Анх | Давтан | Анх | Давтан | Анх | Давтан | Тийм (+) Үгүй (-) | Тийм (+) Үгүй (-) | Тийм (+) Үгүй (-) | | |
| № | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 |
| 1 | | | | | | 1 | 2 | 1 | 2 | 1 | 2 | 1 | 2 | | | | | |
| 2 | | | | | | 1 | 2 | 1 | 2 | 1 | 2 | 1 | 2 | | | | | |
| 3 | | | | | | 1 | 2 | 1 | 2 | 1 | 2 | 1 | 2 | | | | | |
| 4 | | | | | | 1 | 2 | 1 | 2 | 1 | 2 | 1 | 2 | | | | | |
| 5 | | | | | | 1 | 2 | 1 | 2 | 1 | 2 | 1 | 2 | | | | | |
| 6 | | | | | | 1 | 2 | 1 | 2 | 1 | 2 | 1 | 2 | | | | | |

Эмнэлгийн нэр ______________ Илрүүлгийн маягт **(СМУ-1)**

[ ][ ][ ][ ][ ][ ]

## Умайн хүзүүний өмөнгийн илрүүлгийн маягт

*Өрх, сумын эмч/ Өрхийн сувилагч/ Багийн бага эмч/ Эх баригч (зур)*

**А. Хувь хүний бүртгэлийн хэсэг**

1. Регистрийн дугаар: РД [ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ]

   Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар: ЭМД [ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ]
2. Эцэг /эх/-ийн нэр: ______________________
3. Нэр: ______________________
4. Төрсөн ______он ___ сар ___ өдөр
5. Нас: ______
6. Боловсрол: *Бага* ☐ *Дунд* ☐ *Мэргэжил-техникийн* ☐ *Дээд* ☐ *Боловсролгүй* ☐
7. Мэргэжил ______________________
8. Гэр бүлийн байдал: *Нөхөртэй* ☐ *Нөхөргүй* ☐
9. Оршин суугаа хаяг: ______________ аймаг/ дүүрэг ____________ хороо/ баг _____
   ______________________________________________
10. Утас: ______________________

**Б. Үзлэгийн хэсэг**

11. Үзлэгийн хэлбэрүүдийн аль тохирохыг тэмдэглэнэ үү (Тохирох хариултын нүдэнд ✓ тэмдэглэнэ үү)

| | |
|---|---|
| *Хүн амд суурилсан илрүүлэг, эхний удаагийн хамрагдалт* | |
| *Хүн амд суурилсан илрүүлэг, Пап шинжилгээ давтан авах зорилгоор* | |
| *Боломжит илрүүлэг, жирэмсний тээлтийн эхний 3 сарын хугацаанд буй* | |
| *Жирэмсний тээлтийн эхний 6 сарын хугацаанд буй жирэмсний хяналтаар* | |
| *Жирэмсний сүүлийн 3 сарын хугацаанд буй жирэмсний хяналтаар хийгдсэн* | |
| *Бусад боломжит илрүүлэг* | |
| *Илрүүлэг бус, эмнэлзүйн шалтгааны улмаас үзлэгт хамрагдсан* | |

12. Умайн хүзүүний эсийн шинжилгээ авах талаар үйлчлүүлэгчид таниулж зөвшөөрөл авсан эмчийн нэр, гарын үсэг

    /____________________ / ____________________ /

13. Умайн хүзүүний эсийн шинжилгээ авахыг зөвшөөрсөн үйлчлүүлэгчийн нэр, гарын үсэг

    /____________________ / ____________________ /

14. Эсийн шинжилгээ авсан огноо *(оооо/сс/өө)*: [ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ]

15. Үйлчлүүлэгч жирэмсэн эсэх: Тийм ☐ Үгүй ☐

Хэрэв Тийм бол, жирэмсний тээлтийн хугацаа _____

16. Үзлэг хийж, наац бэлтгэсэн эмч/ сувилагчийн нэр, дугаар ______________/

[ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ]

**Заавар:** Эмнэлгийн нэр гэсэн хэсэгт аль аймаг, дүүргийн эмнэлэг болохыг тодорхой бичиж, кодлоно. Өрх, сумын эмчийн хөтөлсөн энэхүү маягтыг тухайн өдөртөө бүртгэгдсэн илрүүлгийн бусад маягтуудын хамт дүн бүртгэлийн эмч нь эргэн дуудах тогтолцооны програмд шивж оруулна. Пап наацыг эс судлалын лабораторид хүргэхээр явахдаа мөн илрүүлгийн маягтуудыг цаасаар аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид хүргэнэ. 16-р асуултад буй эмч, сувилагчийн нэр, дугаар гэсэн хэсэгт өөрийн нэрээ тод, гаргацтай бичих ба дугаар оруулах нүдэнд эргэн дуудах тогтолцооны програмын зүгээс эмч, мэргэжилтэн бүрт олгосон дугаарыг оруулна.

Илрүүлгийн маягт **(СМУ-1/Эс)**

**Умайн хүзүүний эсийн шинжилгээний маягт**

*Өрх, сумын эмч/ Эс судлаач эмч*

**А. Хувь хүний бүртгэлийн хэсэг**

1. Регистрийн дугаар: РД [ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ]
   Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар: ЭМД [ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ]
2. Эцэг /эх/-ийн нэр: ____________________
3. Нэр: ____________________
4. Нас ______
5. Наац илгээсэн эмнэлгийн нэр, код ______________ [ ][ ][ ][ ][ ][ ]

**Б. Асуумж, үзлэгийн хэсэг**

6. Эмэгтэйчүүдийн өгүүлэл: Цэвэршсэн: *Тийм* ☐ *Үгүй* ☐ Тийм бол, хэдэн онд ______

Сүүлийн биеийн юм ирсэн эхний өдөр [ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ]

Үүнээс: Жирэмслэлтийн тоо [ ][ ] Төрөлтийн тоо [ ][ ] Үр хөндөлтийн тоо [ ][ ]

Зулбалтын тоо [ ][ ]

7. Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэдэг эсэх: *Жирэмснээс хамгаалах даавар* ☐ *Ерөндөг* ☐ *Тарилга* ☐ *Суулгац* ☐ *Бэлгэвч* ☐ *Хэрэглэдэггүй* ☐

8. Урьд нь хийгдсэн умайн хүзүүний эсийн шинжилгээний дүгнэлт байна уу: *Тийм* ☐ *Үгүй* ☐

9. Үзлэгээр умайн хүзүүний харагдах байдал: *Цэвэр* ☐ *Улайлттай* ☐ *Цэврүүтэй* ☐ *Хавдрын сэжигтэй* ☐

**В. Эс судлалын шинжилгээний хэсэг**

1. Пап наац хүлээн авсан огноо: *(оооо/сс/өө)* [ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ]
2. Наац шаардлага хангасан эсэх: *Шаардлага хангасан* ☐ *Шаардлага хангахгүй* ☐
3. Эндоцервикал эс байна уу: *Тийм* ☐ *Үгүй* ☐
4. Бэлгийн замын халдвар: *Трихомонад* ☐ *HSV* ☐ *Кокобацилл* ☐ *HPV* ☐ *Үгүй* ☐
5. Урвалж өөрчлөлт: *Үрэвсэл* ☐ *Атрофи* ☐ *Метаплази* ☐ *Реактив өөрчлөлт Үгүй* ☐
6. Эсийн гажигшил:

   6.1 Хавтгай хучуур эс
   ______________________________
   6.2 Булчирхайлаг эс
   ______________________________
   6.3 Бусад хоруу чанартай шинэ эсүүд
   ______________________________

**7. Эсийн шинжилгээний дүгнэлт /онош - Бетезда ангиллаар/** (Тохирох хариултын нүдэнд ✓ тэмдэглэнэ үү)

| | |
|---|---|
| *Хэвийн* | |
| *Хэвшинжгүй хавтгай эсүүд - өөрчлөлт нь тодорхой бус (ASC-US)* | |
| *Хэвшинжгүй хавтгай эсүүд - хучуур эдийн дотор хүнд гэмтэл байхыг үгүйсгэхгүй* | |
| *Хавтгай хучуур эсийн хөнгөн гэмтэл (LSIL)* | |
| *Хавтгай хучуур эсийн дунд зэргийн гэмтэл (HSIL)* | |
| *Хавтгай хучуур эсийн хүнд гэмтэл (HSIL)* | |
| *Байран өмөн* | |
| *Цөмрөн түрсэн өмөн (SCC)* | |
| *Дүгнэлт гаргах боломжгүй (цус ихтэй)* | |
| *Дүгнэлт гаргах боломжгүй (халдвар)* | |
| *Дүгнэлт гаргах боломжгүй (бусад)* | |

8.Нэмэлт тэмдэглэл: ____________________________________________

9. Эс судлаач эмчийн нэр, дугаар ________________/ [ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ]

10. Эсийн шинжилгээний хариуг хүлээлгэн өгсөн огноо:

*(оооо/сс/өө)* [ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ]

**Заавар:** Энэхүү маягтын **А**, **Б** (1-9 дүгээр асуулт) хэсгийг өрх, сумын эмч хөтлөн Пап наацын хамт эс судлалын лабораторид илгээнэ. Наац илгээсэн эмнэлгийн нэр, кодыг тодорхой бичнэ. Эс судлаач эмч **В** хэсэгт эсийн шинжилгээний дүгнэлтийг бичиж, тухайн өдөртөө багтаан эргэн дуудах тогтолцооны програмд шивж оруулна. Эсийн шинжилгээний дүгнэлт бүхий маягтыг аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид цаасаар илгээнэ.

**Энэ маягтын эх хувь нь хадгалах хугацааны туршид Хавдар бүртгэгчид хадгалагдана**

Эмнэлгийн нэр ____________ Илрүүлгийн маягт **(СМУ-2)**

**Умайн хүзүүний өмөнгийн илрүүлгийн маягт**

*Эх барих, эмэгтэйчүүдийн эмч*

**А. Хувь хүний бүртгэлийн хэсэг**

1. Регистрийн дугаар: РД [ ]

 Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар: ЭМД [ ]

2. Эцэг /эх/-ийн нэр: ____________
3. Нэр: ____________ 4. Нас ______
5. Оршин суугаа хаяг: ____________ аймаг/ дүүрэг ________ хороо/ баг _____

**Б. Асуумжийн хэсэг**

6. Урьд нь өрх, сум тосгоны ЭМТ-д илрүүлэг үзлэгт хамрагдсан уу: *Тийм* ☐ *Үгүй* ☐
7. Эмэгтэйчүүдийн өгүүлэл: Цэвэршсэн: *Тийм* ☐ *Үгүй* ☐ Тийм бол, хэдэн онд ______

Сүүлийн биеийн юм ирсэн эхний өдөр [ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ]

Үүнээс: Жирэмслэлтийн тоо ☐☐ Төрөлтийн тоо ☐☐ Үр хөндөлтийн тоо ☐☐
Зулбалтын тоо ☐☐

8. Зовиур: *Бэлгийн хавьтлын үед өвдөх* ☐ *Бэлгийн хавьтлын дараа цус гарах* ☐ *Зовиургүй* ☐
9. Үтрээнээс ялгадас гардаг уу: *Цагаан юм гарах* ☐ *Үнэртэй* ☐ *Цусархаг* ☐ *Идээрхэг* ☐ *Гардаггүй* ☐

10. Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэдэг эсэх: *Жирэмснээс хамгаалах бээлий* ☐ *Ерөндөг* ☐ *Тарилга* ☐ *Суулгац* ☐ *Бэлгэвч* ☐ *Хэрэглэдэггүй* ☐

11. Эсийн шинжилгээний хариу байна уу: *Тийм* ☐ *Үгүй* ☐

**В. Эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг**

12. Үзлэг хийсэн огноо: *(оооо/сс/өө)* [ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ]

13. Эмэгтэйчүүдийн үзлэгээр: (олон сонголттой хариулт)
 Гадна бэлэг эрхтний хөгжил: *зөв* ☐ *дутуу* ☐ *эмгэгтэй* ☐
 Үтрээ: *уужим* ☐ *бачуу* ☐

<u>Умайн хүзүүний харагдах байдал</u>: *Хэвийн* ☐ *Умайн хүзүүний уулзвар хэсэг бүтэн харагдана* ☐ *Уулзвар хэсэг хагас харагдана* ☐ *Уулзвар хэсэг харагдахгүй* ☐ *Үрэвсэлтэй* ☐ *Шархалсан* ☐

*Ур ургацаг харагдана* ☐, ___ *цагийн байрлалд*, ___ *хэмжээтэй*
*Цайвар толбо харагдана* ☐, ___ *цагийн байрлалд*, ___ *хэмжээтэй*
*Хавдрын сэжигтэй* ☐, ___ *цагийн байрлалд*, ___ *хэмжээтэй*

14. Үтрээн дурангийн шинжилгээ хийсэн үү: *Хийсэн* ☐ *Хийгээгүй* ☐ *бол шалтгаан:*

Хэрэв Хийсэн бол, үтрээн дурангийн шинжилгээ хийх талаар үйлчлүүлэгчид таниулж зөвшөөрөл авсан эмчийн нэр, гарын үсэг ____________

Үтрээн дурангийн шинжилгээ хийлгэхийг зөвшөөрсөн үйлчлүүлэгчийн нэр, гарын үсэг
/____________ / ____________ /

Утрээн дурангийн шинжилгээний дүгнэлт:

________________________________________

________________________________________

15. Эдийн шинжилгээ авсан эсэх: *Тийм* ☐ *Үгүй* ☐

Хэрэв Тийм бол, Умайн хүзүүний эдийн шинжилгээ авах талаар үйлчлүүлэгчид таниулж зөвшөөрөл авсан эмчийн нэр, гарын үсэг /__________________ / __________________ /

Умайн хүзүүний эдийн шинжилгээ авахыг зөвшөөрсөн үйлчлүүлэгчийн нэр, гарын үсэг /__________________ / __________________ /

Эдийн шинжилгээнд сорьц илгээсэн огноо: *(оооо/сс/өө)*[ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ]

**Г. Эдийн шинжилгээний дүгнэлт**

16. Эдийн шинжилгээний дүгнэлт илгээсэн лабораторийн нэр, дугаар:

________________ ☐☐☐☐☐☐

17.Эдийн шинжилгээний хариу хүлээн авсан огноо:*(оооо/сс/өө)* [ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ]

18. Эдийн шинжилгээний хариу:

________________________________________

________________________________________

(Тохирох хариултын нүдэнд ✓ тэмдэглэнэ үү)

| | |
|---|---|
| *а/ Хэвийн* | |
| *б/ Хэвшинжгүй хавтгай эсүүд - өөрчлөлт нь тодорхой бус (ASC-US)* | |
| *в/ Хэвшинжгүй хавтгай эсүүд - хүчүүр эдийн дотор хүнд гэмтэл* | |
| *г/ Хавтгай хучуур эсийн хөнгөн гэмтэл (LSIL)* | |
| *д/ Хавтгай хучуур эсийн хүнд гэмтэл (HSIL)* | |
| *е/ Байран өмөн* | |
| *ё/ Цөмрөн турсэн өмөн (SCC)* | |

**Д. Эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн дүгнэлт хэсэг**

19. Төгсгөлийн онош:

*Хэвийн* ☐ *Үрэвсэлтэй* ☐ *CIN 1* ☐ *CIN 2-CIN 3* ☐ *Байран өмөн CIS* ☐ *Цөмрөн түрсэн өмөн* ☐

________________________________________

________________________________________

________________________________ **ӨОУА-10** ☐☐☐.☐

59

20. Арга хэмжээ авч эхэлсэн огноо: *(оооо/сс/өө)* [ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ]

21. Авсан арга хэмжээ:
*Давтан шинжилгээ хийх* ☐ *Дараагийн илрүүлэг үзлэгт хамрагдахыг зөвлөсөн* ☐ *Шаардлагатай эмийн эмчилгээг зөвлөсөн* ☐ *LEEP* ☐ *Конизаци* ☐ *ХСҮТ-д эмчилгээ хийлгэхийг зөвлөсөн* ☐

22. Зөвлөмж, тэмдэглэл

______________________________________________

______________________________________________

______________________________________________

23. Эмчийн нэр, дугаар ____________________/ [ ][ ][ ][ ][ ][ ][ ][ ]

**Заавар:** Энэхүү маягтын эхний 15 асуултыг бөглөж тухайн өдөрт нь Эргэн дуудах тогтолцооны програмд шивж оруулна, давтан авсан эсийн болон эдийн шинжилгээний хариу гарсны дараа дүгнэлтээ гаргаж, үлдсэн асуултуудыг бүрэн бөглөсний дараа маягтыг цаасаар аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид илгээнэ. Програмд ороогүй 16 дугаар асуултаас эхлэх нэмэлт мэдээллийг хавдар бүртгэгч гүйцээн шивж оруулна. Хэрэв үйлчлүүлэгч жирэмсэн бол 19-р асуултад буй төгсгөлийн онош хэсэгт жирэмсний тээлтийн хугацааг тэмдэглэнэ.
Оношийг ӨОУА-10 ангилалын [N][8][7][.][0] дагуу гэж кодлоно.

**<u>Энэ маягтын эх хувь нь хадгалах хугацааны туршид Хавдар бүртгэгчид хадгалагдана.</u>**

Эмнэлгийн нэр ____________________ 

Илрүүлгийн маягт **(СМУ-2/Эд)**

**Умайн хүзүүний эдийн шинжилгээний сорьцын маягт**

*Эх барих, эмэгтэйчүүдийн эмч/*
*Эд судлаач эмч*

**А. Хувь хүний бүртгэлийн хэсэг**

1. Регистрийн дугаар: РД
   Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар: ЭМД
2. Эцэг /эх/-ийн нэр: ____________________
3. Нэр: ____________________
4. Нас _____ Сорьц илгээсэн эмнэлгийн нэр, код ____________
5. Үйлчлүүлэгч жирэмсэн үү? Тийм ☐ Үгүй ☐
   Хэрэв Тийм бол жирэмсний тээлтийн хугацаа ____ долоо хоног
6. Эмнэлзүйн талаархи товч мэдээлэл:

_______________________________________________
_______________________________________________
_______________________________________________

7. Эмнэлзүйн урьдчилсан онош буюу төгсгөлийн онош:

_______________________________________________
_______________________________________________
_______________________________________________

8. Сорьц авсан огноо [ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ] (оооо/сс/өө)
9. Сорьц илгээсэн огноо [ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ] (оооо/сс/өө)
10. Шинжилгээнд сорьц илгээсэн эмчийн нэр, дугаар ____________

**Б. Эд судлалын шинжилгээний хэсэг**

1. Сорьц хүлээн авсан огноо: *(оооо/сс/өө)* [ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ]

2. Эдийн шинжилгээний дүгнэлт, онош /доорх хүснэгтээс сонгон (✓) тэмдэг тавина уу, олон хариулттай байж болно/

___

___

| | | |
|---|---|---|
| 1. | Хэвийн | |
| 2. | Хавтгай эсийн өмөн (хүчүүр эд тест өмөн) | |
| | 2а. эвэршдэг (дунд ба сайн ялгаралтай) | |
| | 2б. эвэршдэггүй (том ба жижиг эсийн хэлбэр) | |
| | 2в. ээрүүл эст өмөн | |
| 3. | Булчирхайлаг өмөнгийн хэлбэр | |
| | 3а. хорт аденома (гаж хувирал багатай өмөн) | |
| | 3б. булчирхайлаг хөхлөгт өмөн | |
| 4. | Булчирхайлаг өмөн (эндометроид) | |
| 5. | Цайвар эст булчирхайлаг өмөн | |
| 6. | Шүүдэст булчирхайлаг өмөн | |
| 7. | Мезонефроид өмөн | |
| 8. | Булчирхайлаг өмөнгийн гадасний хэлбэр ( бөгж хэлбэрийн эс) | |
| 9. | Хавтгай эст булчирхайлаг өмөн | |
| 10. | Уйланхайт булчирхайлаг өмөн | |
| 11. | Жижиг эст өмөн | |
| 12. | Ялгаралгүй өмөн | |
| 13. | Үсэрхийлсэн хавдрууд (хөх, өндгөвч, бүдүүн гэдэс, умайн | |
| 14. | Дүгнэлт гаргах боломжгүй | |

3.Нэмэлт тэмдэглэл: ___

4. Сорьцыг шинжилгээнд бэлтгэсэн лаборантын нэр ___

5. Эд судлаач эмчийн нэр, дугаар ___/ [ | | | | | | | | ]

6. Сорьцын хариуг хавдар бүртгэгчид хүлээлгэн өгсөн огноо:

*(оооо/сс/өө)* [ ][ ][ ][ ]/[ ][ ]/[ ][ ]

<u>Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд</u>

Өрх, сум, тосгоны ерөнхий эмч, их эмч, үндэсний хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн болон статистикч бага эмч, ахлах сувилагч нь хорт хавдрын

өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын бүртгэл мэдээллийг удирдамжийн дагуу аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасаг (хавдар бүртгэгч)-т мэдээлнэ.

<u>Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, хувийн эмнэлэг болон бусад эмнэлэг</u>

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, хувийн эмнэлэг, лабораторийн статистикч, мэдээллийн мэргэжилтэн хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтыг хорт хавдар бүртгэх удирдамжийн дагуу ХСҮТ- ХҮБ-д мэдээлнэ.

**Хорт хавдрыг бүртгэх үйл явц / Хүснэгт 1/**

| № | Эрүүл мэндийн бүртгэлийн маягтууд | Хорт хавдрыг бүртгэж мэдээлэх эрүүл мэндийн мэргэжилтэн | Тайлбар |
|---|---|---|---|
| **Хорт хавдрын бүртгэлийн үндсэн маягт** | | | |
| 1 | Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг мэдээлэх хуудас " Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5" /Хавсралт-1/ | Өрх, сум,тосгоны эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, хувийн эмнэлэг, лабораторийн эмч нар, эрүү нүүр, шүдний эмч нар, шинжээч эмч нар | Байран өмөн/ insitu/; Хорт хавдар, анхдагч байршил; Лимфома, лейкеми; Хорт хавдар үсэрхийлсэн хавдруудыг бүртгэн мэдээлнэ |
| 2 | "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ" АМ-7 | Хорт хавдрын шалтгаант нас баралтын нь эмнэлэг болон гэрт нас барсан тохиолдлыг их эмч | Хорт хавдрын шалтгаант нас баралтыг бүртгэж, нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7 маягтыг хөтлөн хорт хавдар оношлогдсоноос хойш амьдарсан хугацааг заавал тэмдэглэж мэдээлнэ. |
| **Хорт хавдрын бүртгэлд ашиглагдах бусад бүртгэлийн маягтууд** | | | |
| 1 | Өвчний түүх: СТ-1А, 1Б | Төрөлжсөн нарийн мэргэжлийн төвүүдийн эмч | Бүртгэгдээгүй орхигдсон хорт хавдрын тохиолдлыг бусад бүртгэлийн маягтуудыг нотолгоо баримт болгон хавдар бүртгэгч идэвхитэй хайж бүртгэн мэдээлнэ. |
| 2 | Эмчийн үзлэгийн бүртгэл: АМ-1А, 1Б | Улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эмч | |
| 3 | Лабораторийн шинжилгээний хуудсууд: АМ-22 | Эмгэг судлаач эмч | |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Лабораторийн шинжилгээний бүртгэл: АМ-23 | Бүх шатны улсын болон хувийн лабораторийн эмч | |
| 5 | Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдагсдын бүртгэл: АМ-26А, АМ-26Б | Хөнгөвчлөх эмчилгээний эмч, Хосписын эмч | |
| 6 | Шүүх эмнэлгийн задлан шинжилгээний бүртгэл: ШЭ-2, ШЭ-3, ШЭ-9 | Шинжээч эмч | |
| 7 | Эмгэг судлалын шинжилгээний протокол, илгээлт: ЭС-1, ЭС-3 | Эмгэг судлаач эмч | |

**Мэдээний эх сурвалж байгууллагууд:**

I. Эмнэлгийн байгууллагууд:

- Өрхийн эрүүл мэндийн төв
- Сумын эрүүл мэндийн төв
- Тосгоны эрүүл мэндийн төв
- Аймгийн нэгдсэн эмнэлэг
- Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн нэгдэл
- Бүсийн оношлогоо эмчилгээний төв
- Улсын клиникийн төв эмнэлэг
- П.Н. Шастины нэрэмжит төв эмнэлэг
- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
- Арьсны өвчин судлалын үндэсний төв
- Гэмтэл согог судлалын үндэсний төв
- Эмгэг судлалын үндэсний төв
- Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төв
- Цус сэлбэлт судлалын үндэсний төв
- Халдварт өвчин судлалын үндэсний төв
- Клиникийн II нэгдсэн эмнэлэг
- Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын төв
- Геронтологийн төв
- Зэвсэгт хүчний клиникийн төв госпиталь
- Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
- Хувийн эмнэлэг
- Хувийн лаборатори

II. Бусад:

- Эргэн дуудах тогтолцоо -Илрүүлэг үзлэг

III. Эмнэлгийн бус байгууллагууд: /Хавсралт 3/

- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн-Шүүх эмнэлгийн хэлтэс

- Эрүүл мэндийн даатгал
- ЗГХА- Улсын бүртгэлийн ерөнхий газар-иргэний бүртгэлийн газар

**Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг мэдээлэх хугацаа, урсгал**

*Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд*

1. Өрх, сум (тосгон)-ын эмнэлэг, сум дундын эмнэлгийн статистикч бага эмч нь өрх, сум (тосгон)-ын үзлэгийн эмч нараас хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5", хорт хавдрын шалтгаант нас баралтыг "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7" мэдээг өдөр бүр авна.
2. Мэдээг долоо хоног, сараар нэгтгэн нэгтгэлийг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасаг, нэгжийн хавдар бүртгэгчид дараа сарын 1-нд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

*Аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн түвшинд*

1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын статистик мэдээллийн алба, нэгж нь хавдар бүртгэгчээс хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын тохиолдлын тоон мэдээг авч дараа сарын 4-ны дотор ЗГХА-ЭМГазрын СМХэлтэст цахим хэлбэрээр хүргүүлнэ.
2. Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасгийн хавдар бүртгэгч нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, хувийн эмнэлэг, лабораториос улирал бүрийн сүүлийн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа улирлын эхний сарын 2-ны дотор "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5" "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7" -г цаасан болон цахим хэлбэрээр мэдээллийг хүлээж авна.
3. "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5", "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7" маягтын өгөгдлийг ЭМЯ-наас зөвшөөрөгдсөн программд хавдар бүртгэгч шивж мэдээний санд мэдээллийн давхардлыг шалган, мэдээний санг үүсгэнэ.
4. Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасгийн хавдар бүртгэгч хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын цаасан болон цахим мэдээний санг улиралаар нэгтгэн дараа улирлын эхний сарын 10-ны дотор цахим хэлбэрээр, 20-ны дотор цаасан хэлбэрээр ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэлд хүргүүлнэ.
5. Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасгийн хавдар бүртгэгч хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын жилийн тайлан (Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-303 )-г дараа жилийн 1-р сарын 15-ны дотор ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэлд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

*Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд, хувийн эмнэлэг болон бусад эмнэлэг*

1. Мэдээллийн мэргэжилтэн, статистикч нь үзлэгийн кабинет, эмчилгээ, оношлогооны эмч нараас хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5", хорт хавдрын шалтгаант нас баралтыг "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7" маягтаар өдөр бүр хүлээн авна.

2. Сарын мэдээг өссөн дүнгээр улиралд нэгтгэн улирлын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа улирлын эхний сарын 5-ны дотор цахим болон цаасан хэлбэрээр ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэлд хүргүүлнэ.

*Үндэсний түвшинд*

1. ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэл нь мэдээний эх сурвалж байгууллагуудаас "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5 " хорт хавдрын шалтгаант нас баралтыг "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7" маягтын цахим баазыг дараа улирлын эхний сарын 10-ны дотор, цаасан хэлбэрээр 20 ны дотор хүлээн авна.

2. ХСҮТ-ийн амбулатори, стационари хариуцсан статистикч их эмч нь үзлэгийн кабинет, эмчилгээ, оношлогооны эмч нараас хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5" хорт хавдрын шалтгаант нас баралтыг "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7" маягтаар өдөр бүр хүлээн авч сар, улирлаар нэгтгэн улирлын сүүлийн сарын 30-д ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэлд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3. ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэл нь хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын мэдээний санг үндэсний түвшинд нэгтгэн, боловсруулалт, дүн шинжилгээ хийн ЗГХА-ЭМГазрын ЭМСХэлтэст улирал тутмын дараа сарын 20-ны дотор цахим хэлбэрээр мэдээлнэ.

4. ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэл нь хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын жилийн тайланг (Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-303) нэгтгэн жил бүрийн 2-р сарын 15-ны дотор ЗГХА-ЭМГазрын ЭМСХэлтэст цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

(**Хүснэгт 2**. Мэдээллийн төрөл, давтамж, гарах үзүүлэлт, тайлан хариуцах байгууллага)

| Д/Д | Мэдээллийн төрөл (Тайлангууд) | Давтамж | Гарах үзүүлэлт | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|
| 1 | Сар бүрийн хүн амын өвчлөлийн мэдээ | Сар тутам | Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлын тоо<br>Хорт хавдрын шалтгаант нас баралтын тоо | Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд<br>ЗГХА-ЭМГ-ЭМСХ элтэс |
| 2 | Хорт хавдрын жилийн тайлан<br>1. Шинээр оношлогдсон | | Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлын өвчлөлийн тайлангаас | ХСҮТ-ХҮБ<br>Аймаг дүүргийн хавдрын тасаг (статистик мэдээллийн алба, нэгж) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хорт хавдрын өвчлөлийн тайлан-ЭМТ 303.1<br><br>2. Хорт хавдрын шалтгаант нас баралтын тайлан-ЭМТ 303.2<br><br>3. Хорт хавдрын хяналтын тайлан–ЭМТ 303. 4<br><br>4. Шинээр оношлогдсон хорт хавдрын өвчлөлийн эмчилгээний тайлан–ЭМТ 303.3 | | ○ Насны бүлэг<br>○ Хүйс<br>○ Хавдрын төрөл<br>○ Үе шат<br>○ Аймаг, дүүргээр<br>Хорт хавдрын шалтгаант нас баралтын тайлангаас<br>○ Насны бүлэг<br>○ Хүйс<br>○ Хавдрын төрөл<br>○ Хорт хавдраар өвчилсөнөөс хойш амьдарсан хугацаа<br>○ Аймаг, дүүргээр<br>Хорт хавдрын хяналтын тайлангаас<br>○ Хорт хавдраар өвчилсөнөөс хойш амьдарч байгаа хугацаа<br>○ Хүйс<br>○ Хавдрын төрөл<br>○ Үе шат<br>○ Аймаг, дүүргээр<br>Шинээр оношлогдсон хорт хавдрын өвчлөлийн эмчилгээний тайлангаас<br>○ Хавдрын төрөл<br>○ Эмчилгээний хэлбэрээр<br>○ Аймаг, дүүргээр<br>Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлын оношилгоо, шинжилгээний тайлангаас<br>○ Хавдрын төрөл<br>○ Оношилсон шинжилгээний | хавдар бүртгэгч |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 5. Шинээр оношлогдсон хорт хавдрын өвчлөлийн оношилгоо, шинжилгээний тайлан- ЭМТ 303.5 | | төрлөөр<br>○ Аймаг, дүүргээр | |
| 3 | Хорт хавдрын хяналтын тайлан | Жил бүр | Аймаг, дүүргийн хавдрын судлалын кабинетын хяналтанд байгаа өвчтнүүдийн мэдээлэл амьдарсан хугацаа, үе шатаар, хүйсээр, хорт хавдрын төрөл, аймаг, дүүргээр | Аймаг, дүүргийн хавдрын тасаг (статистик мэдээллийн алба, нэгж) |
| 4 | Эрүүл мэндийн үзүүлэлт | Жил бүр | Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлын түвшин 100000 хүн амд<br>Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 100 000 хүн амд<br>Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүдээр | ЗГХА-ЭМГ-ЭМСХ элтэс ХСҮТ |

**Мэдээний агуулга**

1. Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлын мэдээний агуулга

Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлын мэдээ ( Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5) нь дараах мэдээллийг зайлшгүй агуулсан байвал зохино.

Өвчтөний тухай:

- Ургийн овог
- Эцэг эхийн нэр
- Өөрийн нэр
- Регистерийн дугаар
- Төрсөн он сар өдөр
- Нас
- Хүйс
- Мэргэжил
- Боловсрол
- Оршин суугаа хаяг

- Оношилсон хугацаа
- Амьд эсэх

Хорт хавдрын талаарх:

- Эмчид анх үзүүлсэн он сар өдөр
- Эмчилгээ эхэлсэн он сар өдөр
- Оношилсон он сар өдөр
- Анхдагч хавдрын байрлал
- Хорт хавдрыг оношилсон шинжилгээ
- Хорт хавдрын морфологи онош
- Хавдрын төлөв
- Хорт хавдар оношлогдох үеийн үе шат
- Хорт хавдрын эсийн ялгарал

Хорт хавдрын эмчилгээ:

- Анх хийгдсэн эмчилгээний төрөл

2. Хорт хавдрын шалтгаант нас баралтын мэдээ ( Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7) нь дараах мэдээллийг зайлшгүй агуулсан байвал зохино.

- Эцэг эхийн нэр
- Өөрийн нэр
- Регистерийн дугаар
- Төрсөн он сар өдөр
- Нас
- Хүйс
- Мэргэжил
- Боловсрол
- Нас барах үеийн оршин суугаа хаяг
- Нас барсан газар
- Нас барсан он сар өдөр
- Нас баралтын шалтгаан
- Оношилсоноос хойш амьдарсан хугацаа

**Мэдээллийн сан, хадгалах хугацаа**

1. Мэдээний эх сурвалж байгууллагууд хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын мэдээллийн санг үүсгэхдээ "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5", "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7" маягтын дагуу өдөр бүр ЭМЯ-наас зөвшөөрсөн хорт хавдрын бүртгэлийн программд шивнэ.

2. Мэдээний эх сурвалж байгууллагууд үүссэн мэдээллийн санг сар, улирал, жилээр нэгтгэн хадгална.

3. ХСҮТ-ХҮБ нь үндэсний хэмжээнд " Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5", " Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7 " цаасан маягтаар нэгтгэсэн мэдээллийн санг 10 жил, үүнээс цааш хугацаанд цаасан маягтыг архивлахдаа скайнердан CD хуулбарлан дахин 10 жил, цахим мэдээллийн нэгтгэсэн санг 20 жил хадгална.

**Мэдээллийн чанарын хяналт**

Мэдээллийн чанарын хяналт нь тоон үзүүлэлтийг чанартай боловсруулах, мэдээний чанарыг тодорхой шалгуур үзүүлэлтээр үнэлэх, саад болж буй бэрхшээл, сул талыг тодорхойлох, хэрэгжүүлэх шатанд ажиллаж буй ажилтнуудад дэмжлэгт хяналт хийх, мэдээний чанар болон тогтолцоог сайжруулах арга хэмжээний санал, зөвлөмж боловсруулах, мэдээллийн тогтолцоог бүхэлд нь үнэлэн үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдэнэ.

Мэдээллийн чанарын хяналт, аудитыг тодорхой давтамжтайгаар хийсэнээр юунд анхаарах шаардлагатайг илрүүлнэ. Мэдээллийн чанарын хяналтыг дараах 3 түвшинд

а. Тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн болон бусад салбарын байгууллагууд
б. Аймаг , дүүрэг
в. Үндэсний түвшинд (мэдээ тайлан нэгтгэдэг алба, нэгж) мэдээг цуглуулах, дамжуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, түгээх үйл ажиллагааны явцаар хянана.

Мэдээний чанарын хяналтыг мэдээний чанарыг үнэлэх хөндлөнгийн хяналт (гадны шинжээчийн багийг томилох) байнгын дэмжлэгт хяналт ( хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, нэгж байгууллагуудын шинжээчийн багийг томилох) гэсэн 2 үндсэн хэлбэрээр хийнэ.

Мэдээний чанарыг үнэлэх хөндлөнгийн болон дэмжлэгт хяналт нь 2 үндсэн бүрэлдэхүүнтэй.

- Мэдээллийн тогтолцооны үнэлгээ
- Мэдээллийн чанарын хяналт

Мэдээллийн тогтолцооны үнэлгээг

а. Тусламж үйлчилгээ үзүүлж байгаа үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн болон бусад байгууллагууд
б. Аймаг , дүүрэг
в. Үндэсний түвшинд (мэдээ тайлан нэгтгэдэг алба, нэгж) хийнэ.

Мэдээллийн тогтолцооны үнэлгээ нь үйл ажиллагааны 5 үндсэн бүрэлдэхүүнтэй. Үүнд:

- Хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцооны бүтэц, хүний нөөцийн чадавх
- Үзүүлэлтийн тодорхойлолт, удирдамж, журам, заавар, аргачлал
- Мэдээг цуглуулах анхан шатны бүртгэл, тайлангийн маягт
- Мэдээний нэгтгэл, дүн шинжилгээ, тайлагналт
- Мэдээний урсгал, дамжуулалт, эргэн мэдээлэл

Мэдээллийн чанарын хяналтыг

а. Эрүүл мэндийн болон бусад байгууллагууд
б. Аймаг , дүүргийн
в. Үндэсний түвшинд (мэдээ тайлан нэгтгэдэг алба, нэгж) хийнэ. Үндэсний

хэмжээнд мэдээллийн сан үүсгэн тайлагнадаг алба, хэлтсүүдийн мэдээллийн сан тайлангийн үнэн бодит байдал, эргэн мэдээллийн байдалд мэдээллийн чанарын хяналтыг хийнэ. /Зураглал 1/

Зураглал 1. <u>Мэдээллийн чанарын хяналт</u>



**Тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын алба, нэгжүүдийн түвшинд мэдээний үнэн магадыг шалгах хэлбэрүүд**

**/Хүснэгт 3/**

| Үнэн магадыг шалгах хэлбэр | Шинж чанар |
|---|---|
| Тодорхойлолт | Хорт хавдрын бүртгэл, тайлагналтын хоорондын уялдааг тодорхойлох |
| Баримтын судалгаа | Тайлант хугацаанд мэдээлсэн тоон үзүүлэлтүүд хорт хавдрыг мэдээлэх үндсэн маягтын бүрэн гүйцэд байдлыг үнэлэх |
| Мэдээний үнэн бодит байдлыг нягтлах | А. Тайлант хугацаанд мэдээлсэн тоон үзүүлэлтийг анхан шатны бүртгэлийн маягттай тулгах, дахин нягтлах<br>Б. Тайлант хугацаанд мэдээлсэн тоон үзүүлэлтийг дахин нягтлан шалгасан үзүүлэлтүүдийн дүнтэй харьцуулах<br>В. Хэрэв зөрөө байвал шалтгааныг тогтоох |
| Хөндлөнгийн хяналт | Тоон үзүүлэлтийн анхан шатны бүртгэлийг бусад боломжтой бусад мэдээний эх сурвалжтай тулгах |
| Санамсаргүй түүвэрлэлт | Боломжтой бол тусламж үйлчилгээг авсан үйлчлүүлэгчдээс санамсаргүйгээр сонгон өгөгдлийн үнэн магадлыг нягтлах |

**Аймаг, дүүрэг, үндэсний түвшинд мэдээ тайлан нэгтгэдэг алба, нэгжүүдийн түвшинд мэдээний үнэн магадыг шалгах хэлбэрүүд**

| | |
|---|---|
| Тодорхойлолт | Хорт хавдрын бүртгэл, тайлагналтын хоорондын уялдааг тодорхойлох |
| Баримтын судалгаа | Тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудаас тайлант хугацаанд ирүүлсэн тайлан бүрэн гүйцэд, цаг хугацаандаа ирсэн эсэхийг үнэлэх |
| Мэдээний үнэн бодит байдлыг нягтлах | А.Тоо, мэдээний нэгтгэлийг дахин нягтлах<br>Б.Дахин нягталсан тоо мэдээний нэгтгэлийг үндсэн түвшинд мэдээлсэн тоо мэдээтэй харьцуулан нягтлах<br>В.Хэрэв зөрөө байвал шалтгааныг тогтоох |

**Хорт хавдрын бүртгэлд хэрэглэгдэх программ хангамж**

- Хорт хавдрын бүртгэлийн програм
- Монгол улсын эрүүл мэндийн салбарт нэгдсэн журмаар хэрэглэгдэж буй програм хангамж

**Мэдээ, мэдээллийн нууц**

1. Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралт, хорт хавдрын хяналтын тухай мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарагдах тул мэдээг мэдээлж байгаа их эмч, эмнэлгийн мэргэжилтэн, хорт хавдрын бүртгэлийн бүх түвшинд мэдээллийн нууцыг чанд хадгална.

2. Судалгаанд хорт хавдрын тухай мэдээллийг гаргахдаа хувь хүний нууцтай холбоотой хэсгийг нууцална.
3. Мэдээ, мэдээллийн нууцтай холбоотой санал гомдлыг ЭМЯ-ны ёс зүйн хороо болон тухайн байгууллагын ёс зүйн салбар хороо хүлээн авч шийдвэрлэнэ.

**Мэдээг мэдээлээгүй тохиолдолд хүлээх хариуцлага**

Эмч, мэдээллийн мэргэжилтэн хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг мэдээлээгүй нь батлагдсан хорт хавдар бүртгэх удирдамж болон холбогдох хууль дүрмийг дагаж мөрдөөгүй ажил үүргээ цалгардуулсан тохиолдолд холбогдох хууль дүрмийн дагуу хариуцлага хүлээнэ. / ЭМС-34 тоот тушаалын Эрүүл мэндийн сайдын 2010 оны 02 дугаар сарын 02 өдрийн 34 тоот тушаалын нэгдүгээр хавсралт 3.6 заасаны дагуу шийдвэрлэнэ/

**Мэдээлэл түгээх бодлого /Хүснэгт 4/**

Мэдээллийн бүтээгдэхүүн ба түгээлт

| Д/Д | Мэдээллийн бүтээгдэхүүн | Давтамж | Мэдээллийг түгээх хэлбэр | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|
| 1 | Сар бүрийн хүн амын өвчлөлийн мэдээнд хорт хавдрын мэдээллүүд тоон байдлаар | Сар тутам | Цахим шуудан, Мэдээллийн товхимол, веб хуудас | ЗГХА-ЭМГ-ЭМСХэлтэс |
| 2 | Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын улирлын тайлан | Улирал, хагас жил | Цахим шуудан, Веб хуудас, товхимол | Аймаг, дүүргийн хавдрын тасаг ХСҮТ-ХҮБ |
| | Үндэсний хэмжээнд хорт хавдрын тайлан | Жил бүр | Цаасан болон цахим, товхимол, веб хуудас, танилцуулах уулзалт | ХСҮТ-ХҮБ |
| 4 | Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн жилийн тайлан | Жил бүр | Зөвлөлдөх уулзалт, хэвлэмэл | Аймаг, дүүргийн ЭМГ, ЭМЯ, ХСҮТ |
| 6 | Эрүүл мэндийн үзүүлэлт | Жил бүр | Цаасан болон цахим, товхимол, веб хуудас, танилцуулах уулзалт | ЗГХА-ЭМГ-ЭМСХэлтэс |
| 9 | Бусад үнэлгээ, судалгааны ажлын тайлан | Тухай бүр | Танилцуулах уулзалт, Хэвлэмэл, үндэсний мэдээний сан | Гүйцэтгэсэн байгууллага, ХСҮТ |

**Техник хангамж**

Хорт хавдрын бүртгэлийн хэсэг, нэгжүүд нь орчин үеийн шаардлага хангасан компьютер, принтер, скайнер, суурин утас, интернэтээр хангагдсан байх

**Санхүүжилт**

1. Хорт хавдрын бүртгэл мэдээлэл нь улсын төсөв болон бусад санхүүгийн эх үүсвэрээр санхүүжинэ.
2. ХҮБ-ийн хэсэг, нэгжүүдийн үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийг байгууллагууд жил бүрийн төсөвдөө тусгах үүрэгтэй.

Хавсралт-1

ЭМСайдын 200_ оны ___ тоот тушаалаар батлав АМ-8

# ХОРТ ХАВДРЫГ МЭДЭЭЛЭХ ХУУДАС

## I. Хувь хүний мэдээлэл

1. Ургийн овог
2. Эцэг/эх/-ийн нэр
3. Нэр

4. РД
5. Нас /жилээр/
6. Хүйс: эр 1 эм 2

| 7. Боловсрол | | |
|---|---|---|
| | Бага | 1 |
| | Бүрэн дунд | 2 |
| | Мэргэжлийн | 3 |
| | Дээд | 4 |
| | Боловсролгүй | 5 |

8. Төрсөн огноо /0000/сс/өө/
9. Ажлын газар
10. Албан тушаал
11. Мэргэжил

12. Гэрлэлтийн байдал: гэрлэсэн -1, гэрлээгүй -2, тодорхойгүй -9
13. Одоогийн оршин суугаа хаяг

Холбогдох утас

| 14. Хэр мэдээлсэн ЭМ | | |
|---|---|---|
| | Өрхийн эмнэлэг | 1 |
| | Дүүргийн эмнэлэг | 2 |
| | Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэг | 3 |
| | Эрт илрүүлгийн үзлэг | 4 |
| | Хувийн хэвшлийн ЭМБ | 5 |
| | Хувийн хэвшлийн лаборатори | 6 |
| | Эмгэг судлалын төв | 7 |
| | Шүүх эмнэлэг | 8 |

15. Хавдар оношлогдсон огноо: ________ он _____ сар _____ өдөр

16. Өвчтөний одоогийн байдал: | амьд -1, нас барсан -2, тодорхойгүй -9

## II. Хорт хавдрын мэдээлэл

17. Анхдагч хавдрын байрлалын оношл

18. Кодыг Хавдрын олон улсын 3 -р ангиллын (ICD-O-3) дагуу бөглөнө

19. Бүтэц зүйн онош:

19.1. Хавдрын төлөв: Байрлал [illegible] -2, Хортой-3, Үсэрхийлсэн-6

19.2. Эсийн ялгарал: Өндөр ялгаралтай - 1, Дунд ялгаралтай - 2, Бага ялгаралтай - 3, ялгаралгүй - 4, Ялгарлын зэрэг тодорхойлогдоогүй -9

19.3. Лимфома, лейкемийн эсийн ялгарал: T-эсийн -5, B -эсийн /pre-B, B-precursor/ -6, Null /non-T & non-B/ эсийн -7, Killer /natural killer/ эсийн - 8, эсийн төрөл нь тодорхойлогдоогүй -9

20. Кодыг Хавдрын олон улсын 3 -р ангиллын (ICD-O-3) дагуу бөглөнө

| M | | | | | / | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Асуулт 22 | | | | | 22.1-22.5 | |

21. Анхдагч олон байрлалын хавдар мөн эсэх: анхдагч ганц байрлалын хавдар -1, анхдагч олон байрлалын хавдрын нэг тохиолдол -2, тодорхойгүй -9

21.1. Хос эрхтэний хавсарсан эсэх: Баруун-1, Зүүн-2, Нэг талын хавсарсан болох нь тогтоогдоогүй-3, Хоёр талын хавсарсан-4, Хос эрхтэн биш-5

22. Хавдрыг оношилсон шинжилгээ ба үндэслэл

| Бичил харуурын | Бичил харуурын бус |
|---|---|
| 1 - Эсийн ба цусны<br>2 - Анхдагч хавдрын эдийн<br>3 - Үсэрхийлсэний эдийн<br>4 - Задлан шинжилгээний | 5 - Нас баралтын гэрчилгээ<br>6 - Лабораторийн оношилгоо /хавдрын өвөрмөц маркер, иммунологи/<br>7 - Дүрс оношилгоо /КТГ, дуран, рентген, ЭХО, MRI .../<br>8 - Хагалгааны дүгнэлт<br>9 - Эмнэл зүйн бүрдэл шинж<br>10 - Бусад<br>99 - Тодорхойгүй |

23. Оношлогдох үе дэх хавдрын үе шат: T - is, 1, 2, 3, 4, X N - 0, 1, 2, 3, X M - 0, 1, X

24. Хавдрын эмнэл зүйн үе шат: I, II, III, IV ба үүнээс хэтэрсэн бичигдэх бол

| 25. Хийгдсэн эмчилгээ: /хамгийн сүүлийн/ | | | | |
|---|---|---|---|---|
| | Мэс засал | 1 | Химитуяагаар эмчилгээ | 8 |
| | Туяа | 2 | Дархлаа дэмжих эмчилгээ | 9 |
| | Хими | 3 | Дааврын эмчилгээ | 10 |
| | Мэс засал+туяа | 4 | Хөнгөвчлөх мэс засал | 11 |
| | Мэс засал+хими | 5 | Бусад хөнгөвчлөх эмчилгээ, туслашлуулах | 12 |
| | Туяа+хими+мэс засал | 6 | Бусад | 13 |
| | Хими+туяа | 7 | Эмчилгээ хийгээгүй татгалзсан | 14 |

26. Хийгдсэн мэс заслын нэр / Үйлдлийн ОУ-ы ангиллаар төвөл, кодлох /

26.1. Мэс засал хийгдсэн эмнэлэг

## III. Мэдээний эх сурвалж:

/Хорт хавдрын шинэ тохиолдол нь шүүх эмнэлэг, эмгэг судлалын шинжилгээгээр батлагдсан тохиолдолд мөн бөглөнө/

27. Мэдээлсэн байгууллагын нэр

27.1. Мэдээлэгдсэн баримтын дугаар

27.2. Мэдээлсэн эмгэг судлалын лабораторийн нэр

27.3. Эмгэг судлалын шинжилгээний дугаар

27.4. Эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт

28. Бусад эх сурвалж: Баримтын дугаар

29. Мэдээлсэн эмчийн нэр Мэдээлсэн эмчийн гарын үсэг, тамга, тэмдэг

30. Мэдээлсэн огноо: /______ он/ ______ сар/ ______ өдөр/

**Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5 хөтлөх зааварчилгаа**

ЭМСайдын 2010 оны 02 сарын 34 тоот тушаалаар хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5" маягтыг баталсан. АМ-5 маягтыг хүснэгтийн аргачлал, жишээг ашиглан хөтөлнө.

| Асуумж | Аргачлал-Тодорхойлолт - Жишээ |
|---|---|
| **I. Хувь хүний тухай мэдээлэл** | |
| Дугаар 1-3: Өвчтний ургийн овог, эцэг эхийн нэр, нэр | Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн тод гаргацтай, татлахгүйгээр үнэн зөв бичнэ |
| Дугаар 4: Өвчтний регистрийн дугаар | Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ.<br><br>Анхаарах зүйл: РД гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр дармалаар, сүүлийн 8 нүдэнд цифрийг нүд тус бүрт гаргацтай тод бичнэ.<br>Жишээ нь:<br>А \| Ю \| 7 \| 8 \| 1 \| 2 \| 2 \| 9 \| 1 \| 3 |
| Дугаар 5: Өвчтөний нас | Нас гэсэн 3 нүд бүхийн хүснэгтэд насыг бичихдээ төрсөн он сарыг үндэслэн насыг тооцоолж эхний нүдэнд зуутын орон, дунд нүдэнд аравтын орон, сүүлийн нүдэнд нэгжийн орон байхаар тохируулж бичнэ. Жишээ нь: насыг тооцоход 3 настай гэж гарсан бол<br>0 \| 0 \| 3<br>гэж бичнэ. Хэрэв сар болон хоногтой бол нэгжийн оронг 0 болгож хүснэгтийн гадна тоог тавиад сар, хоног аль нь болохыг бичнэ.<br>Анхаарах зүйл: Өвчтөний насыг мэдэх боломжгүй, нотлох бичиг баримт огт байхгүй бол - хорт хавдрын онош тавигдсан он сар өдрөөр тооцоолно. |
| Дугаар 6: Хүйс | Эрэгтэй- 1, Эмэгтэй бол 2-ийг дугуйлна |
| Дугаар 7: Боловсрол | Боловсрол бага -1 /дунд сургуулийн 1- 4-р ангийг төгссөн /<br>Боловсрол дунд-2 /дунд сургуулийн 5-11-р ангийг төгссөн/<br>Боловсрол мэргэжлийн-3 /Мэргэжлийн болон техникийн коллеж төгссөн/<br>Боловсрол дээд-4 /Их дээд сургууль төгссөн/<br>Боловсролгүй -5 /ямар нэгэн сургууль төгсөөгүй буюу сургуульд ороогүй хамааруулна/ |

| | |
|---|---|
| Дугаар 8: Төрсөн он сар өдөр | Асуултанд харгалзах 8 нүд бүхий хүснэгтэнд эхний 2 нүдэнд өдөр, дараагийн 2 нүдэнд сар, сүүлийн 4 нүдэнд оныг бүтнээр бичнэ. Төрсөн он сар өдрийг бичихдээ өвчтөний иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн бичнэ.<br>Жишээ: 1961 он 09 сар 17<br>1 \| 7 \| 0 \| 9 \| 1 \| 9 \| 6 \| 1<br>Анхаарах зүйл:<br>Төрсний гэрчилгээ аваагүй бол төрөлтийн түүхэн дэх төрсөн он сар өдрийг бичнэ. Төрсөн он сарыг мэдэх боломжгүй тохиолдолд оныг мэдэж байвал сар өдрийг 01 сарын 01-ээр авна. |
| Дугаар 9: Ажлын газар | Өвчтөний хорт хавдрын онош батлагдах үед хийж гүйцэтгэж байгаа ажлын газрыг бичнэ. Харгалзах 2 нүдэнд ажлын газрын кодыг ЭМСайдын 34-р тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхтгэл номын Хүснэгт №3-ийг ашиглана.<br>Жишээ: Боловсролын салбарт ажилладаг бол<br>1 \| 6<br>гэж бичнэ.<br>Анхааруулга: Ажлын газаргүй буюу аль нэг кодод ороогүй ажлын газар бол 22-ыг сонгоно. |
| Дугаар 10: Албан тушаал | Хорт хавдрын онош тавигдах үеийн албан тушаалыг бичнэ. Харгалзах 2 нүдэнд албан тушаалын кодыг доорхи жагсаалтыг ашиглан бичнэ.<br>Ажилчин-1<br>Албан хаагч-2<br>Малчин-3<br>Тэтгэвэрт-4<br>Оюутан-5<br>0-15 насны хүүхэд-6<br>Групп болон бусад-7<br>Ажилгүй-8<br>Жишээ: Их эмч бол албан тушаалыг албан хаагчаар авна.<br>0 \| 2<br>гэж кодлон бичнэ |
| Дугаар 11: Мэргэжил | Өвчний амьдралынхаа ихэнх хугацаанд ажиллаж өнгөрүүлсэн болон тухайн мэргэжилээр нарийвчлан сурч ажилласан мэргэжлийг бичнэ. Харгалзах 2 нүдэнд доорхи кодуудаас сонгон бичнэ. ЭМСайдын 34-р тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхтгэл номын Хүснэгт №4-ийг ашиглана.<br>Жишээ: мэргэжил багш бол |

| | |
|---|---|
| | \| 0 \| 4 \|<br>гэж бичнэ. |
| Дугаар 12: Гэрлэлтийн байдал | Гэрлэсэн бол-1, Гэрлээгүй бол -2, тодорхойгүй бол – 3-ийн аль тохирохыг сонгон дугуйлна. |
| Дугаар 13: Одоогийн оршин суугаа хаяг<br>Холбогдох утас: | Өвчтөний иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг, хот, сум, дүүрэг, хороо, хаалганы дугаар зэргийг гаргацтай тод бичнэ. Харгалзах 6 нүд бүхий хүснэгтэнд ЭМСайдын 34-р тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхэтгэл номын Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ангилал Хүснэгт №1-ийг ашиглан кодыг сонгон эхний 2 нүдэнд аймаг, хотын, дунд 2 нүдэнд сум, дүүргийн, сүүлийн 2 нүдэнд баг, хорооны кодыг бичнэ.<br>Жишээ: Хөвсгөл аймгийн рашаант сум 1-р хороо гэсэн бол<br>\| 1 \| 7 \| 1 \| 1 \| 0 \| 1 \|<br>гэж бичнэ.<br>Холбогдох утас: өвчтөнтэй холбоо барих ар гэрийнхэний, өвчтөний өөрийн утасны дугаарыг нэг бүрчлэн бичнэ. |
| Дугаар 14: Хорт хавдар оношилсон Эрүүл Мэндийн Байгууллага | Хорт хавдрыг оношилсон Эрүүл Мэндийн Байгууллагыг сонгон дугуйлна. |
| **II. Хорт хавдрын мэдээлэл** | |
| Дугаар 15: Хавдрыг оношилсон гноо | Хавдрыг оношлосон шинжилгээ ба бусад үндэслэлийн дагуу хавдрын онош батлагдсан хамгийн эхний он, сар, өдрийг тооцон тавина. |
| Дугаар 16 : Өвчтөний одоогийн байдал | Хорт хавдар оношлогдох үед тухайн хүний байдал<br>Амьд-1, Нас барсан-2, Тодорхойгүй-3 –ийн аль тохирохыг сонгон дугуйлна.<br>Нас барсан огноог нас баралтын гэрчилгээг үндэслэн бичнэ. |
| Дугаар 17 : Анхдагч хавдрын байрлалын онош | Хүний биеийн эрхтэн системийн аль хэсэгт хавдар байрлаж байгааг тодорхой заасан оношыг дэлгэрэнгүй бичнэ. Өөрөөр хэлбэл Өвчний олон улсын ангилал - Хавдар судлалыг ашиглан анхдагч хавдрын байрлалын оношийг бичмэлээр тавина. |
| Дугаар 18: Олон улсын өвчний ангилал-хавдар судлал-3 | Олон улсын өвчиний ангилал-хавдар судлал-3 тавина. Жишээ: Ходоодны их биеийн хэсгийг хамарсан хорт хавдар С16.3 гэж кодлоно.<br>Өвчний олон улсын ангилал - Хавдар судлал цусны хорт хавдрын / лейкеми/ C42<br>\| C \| 1 \| 6 \| . \| 3 \| |

| | |
|---|---|
| Дугаар 19: Морфологийн онош | Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн төрөл, төлөв байдлыг дэлгэрэнгүй бичнэ |
| Дугаар 19.1: Хавдрын төлөв | Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн төлөв байдлыг үндэслэн аль тохирохыг дугуйлна. |
| Дугаар 19.2: Эсийн ялгарал | Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн ялгаралыг сонгон тохирохыг дугуйлна. |
| Дугаар 19.3: Лимфома, лейкемийн эсийн ялгарал | Цусны хавдруудын үед эсийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн аль тохирохыг дугуйлна. |
| Дугаар 20. Хавдрын бүтэц зүйн оношын код | М үсгээр эхэлсэн 8 нүд бүхий хүснэгтэнд Олон улсын өвчний ангилал-хавдар судлал-3 номыг ашиглан хавдрын бүтэц зүйн оношыг кодоор бичнэ.<br>Эхний нүдэнд М үсэг, дараагийн 4 нүдэнд хавдрын эсийн төрөл, 6 дах нүдэнд ташуу зураас, 7 дахь нүдэнд хавдрын эсийн төлөв, 8 дах нүдэнд хавдрын эсийн ялгаралын кодуудыг бичнэ.<br>Жишээ нь: Аденокарцинома- хортой- бага ялгаралтай бол<br>М \| 8 \| 1 \| 4 \| 0 \| / \| 3 \| 3 |
| Дугаар 21. Анхдагч олон байрлалын хавдар мөн эсэх | Анхдагч ганц байрлалын хавдар -1<br>Анхдагч олон байрлалын хавдрын нэг тохиолдол-2<br>Тодорхойгүй -3 |
| Дугаар 21.1 Хос эрхтэний хавдар мөн эсэх: | Баруун -1<br>Зүүн -2<br>Нэг талыг хамарсан боловч ялгаж тусгаагүй -3<br>Хоёр талыг хамарсан - 4<br>Хос эрхтэн бус -5 |
| Дугаар 22. Хавдрыг оношлосон шинжилгээ ба үндэслэл | Бичил харуурын болон бичил харуурын бус хүснэгтээс аль тохирохыг дугуйлна. |
| Дугаар 23. Оношлогдох үеийн хавдрын үе шат / Олон улсын TNM ангилалыг баримтлан тавина/ | **Т- нь анхдагч хавдрын хэмжээ /тархалт/**<br>T-is Байран өмөн<br>То- Анхдагч хавдар тодорхойлогдохгүй<br>T1,T2,T3,T4-Анхдагч хавдрын тархалтыг тодорхойлно<br>**N- Хавдар орчмын тунгалгийн булчирхай**<br>No- Тунгалагийн булчирхайг гэмтээсэн шинж тэмдэггүй.<br>N1,N2, N3- Тунгалагийн булчирхайг хир зэрэг гэмтээснийг илэрхийлнэ.<br>Nx- Тунгалагийн булчирхай гэмтсэнийг тогтоох боломжгүй.<br>**М- Эрхтэнд үсэрхийлэлтэй эсэхийг харуулна**<br>Мо- Алсын эрхтэнд үсэрхийлэлийн шинж |

10

| | |
|---|---|
| | тэмдэггүй.<br>M1- Алсын эрхтэнд үсэрхийлэлтэй.<br>Mx- Алсын эрхтэнд үсэрхийлэл байгаа эсэхийг тогтоох боломжгүй. |
| Дугаар 24. Хавдрын эмнэл зүйн үе шат | I, II, III, IV Ромбо тоог ашиглан хавдрыг эмнэл зүйгээр нь үе шатаар ангилна. |
| Дугаар 25. Хийгдсэн эмчилгээ | Хавдрын онош батлагдсан үеэс эхлэн эхний курс эмчилгээний төлөвлөгөө болон хийсэн эмчилгээг эмчилгээний хүснэгтээс аль тохирохыг сонгон харгалзах тоог дугуйлна. |
| Дугаар 26-26.1. Хийгдсэн мэс заслын нэр, мэс засал хийсэн эмнэлэг, эмч | Мэс заслын нэрийг дэлгэрэнгүй гаргацтай тод бичнэ.<br>Мэс заслын үйлдлийн кодыг ICD-9-CM- Үйлдлийн Олон Улсын ангилал 9 - III ботийг ашиглана. |
| **III. Мэдээний эх сурвалж:** /Хорт хавдрын шинэ тохиолдол нь шүүх эмнэлэг, эмгэг судлалын шинжилгээгээр батлагдсан тохиолдолд мөн бөглөнө /. | |
| Дугаар 27-27.1-4.Мэдээлсэн байгууллагын нэр, мэдээлэгдсэн баримтын дугаар, шинжилгээний дүгнэлт: | Хорт хавдрыг оношилсон лаборатори, эмгэг судлалын төв, шүүх эмнэлгээс мэдээлэгдэж байгаа тохиолдол байгууллагын нэр, баримтын дугаар, шинжилгээний дүгнэлтийг дэлгэрэнгүй бичиж АМ-5 маягтын <u>I. Хувь хүний мэдээллийн</u> хэсгийг заавал бөглөнө.<br>Хорт хавдрыг мэдээлж байгаа бусад эрүүл мэндийн байгууллагууд байгууллагынхаа нэрийг бичмэлээр бичин эрүүл мэндийн сайдын 34 тоот тушаалд заагдсан кодыг нүдэнд бичнэ.<br>Жишээ нь: ХСҮТ мэдээлэгдсэн бол: \| 2 \| 0 \| 0 \| 2 \| 1 \| 1 \|<br>20- Улаанбаатар хот<br>02- Баянзүрх дүүрэг<br>11- ХСҮТ |
| Дугаар 28. Бусад эх сурвалж | Эмнэлгийн бус мэдээний эх сурвалж байгууллагуудаас мэдээлэгдэх тохиолдолд тухай оныг тавин 99 тоогоор кодлоно |
| Дугаар 29. Мэдээлсэн эмчийн нэр | Тухайн хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг мэдээлсэн их эмч |

| | |
|---|---|
| Дугаар 30. Хүлээн авсан бүртгэлийн ажилтан | Аймаг, дүүргийн хавдрын бүртгэлийн ажилтан уг маягтыг хүлээн аваад бүрэн хөтлөгдсөн эсэхийг шалгаж мэдээлэл бүрэн болсон тохиолдолд мэдээлнэ. |

Зураглал-2: Хорт хавдрын мэдээллийн урсгал



Хавсралт 3.

**Мэдээний эх сурвалж эмнэлгийн бус байгууллагаас хорт хавдрын шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтыг бүртгэх, мэдээлэл авах үндэслэл.**

Эрүүл мэндийн даатгалын сан

Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй орхигдсоныг олж бүртгэх зорилгоор хорт хавдрыг идэвхитэй хайх аргаар жилд нэгээс хоёр удаа Эрүүл мэндийн даатгалын сангаас хайж бүртгэнэ. Эрүүл мэндийн даатгалын санд хорт хавдрын оношоор бүртгэгдсэн тохиолдолын мэдээллийг ялган авч ХСҮТ, ХҮБ хорт хавдрын хяналтын мэдээллийн санд тэдгээр өвчтөний мэдээллийг тулгалт хийн шүүн үзэн уг хорт хавдрын тохиолдол хяналтын мэдээллийн санд бүртгэгдээгүй тохиолдолд бүртгэн авч харьяа орон нутгийн хавдрын тасагт мэдээлнэ. Уг үйл ажиллагаа ХСҮТ-ХҮБ, аймаг дүүргийн хавдрын тасгийн хавдар бүртгэгч хариуцан гүйцэтгэнэ.

ЗГХА- Улсын бүртгэлийн ерөнхий газар-иргэний бүртгэлийн газрын мэдээллийн сан

ХСҮТ, ХҮБ нь жилд нэг удаа ЗГХА- Улсын бүртгэлийн ерөнхий газар-иргэний бүртгэлийн газарт хорт хавдрын шалтгаант нас баралт, хорт хавдрын өвчлөлийн хяналтын мэдээллийн сангийн хувь хүний мэдээллийг /өвчтөний овог нэр, ригестрийн дугаар, нас барсан эсэх гэх мэт/ магадлах зорилгоор мэдээллийг тулган шүүн үзнэ. Иргэний бүртгэлээс ХСҮТ-ХҮБ-д хорт хавдрын шалтгаант нас баралт бүртгэгдээгүй тохиолдолд илэрвэл ХСҮТ-ХҮБ нөхөн бүртгэнэ.

Аймаг, дүүргийн хавдрын тасаг нь жилд нэг удаа Харьяа орон нутгийн иргэний бүртгэлийн газарт хандан тухайн жилийн нийт нас баралтын санд хорт хавдрын шалтгаант нас баралтыг шүүн үзэж танай мэдээллийн санд бүртгэгдээгүй тохиолдлыг бүртгэнэ. Хорт хавдрын өвчлөлийн хяналтын мэдээллийн сангаас хувь хүний мэдээллийн /өвчтөний овог нэр, ригестрийн дугаар, нас барсан эсэх/ хэсгийг тохирч байгааг тулган шүүн нягтлан мэдээллийг үнэн зөв болгоно. Хэрвээ хорт хавдрын шалтгаант нас баралт нь аймаг, дүүргийн хавдрын тасагт бүртгэгдээгүй тохиолдолд бүртгэн ХСҮТ-ХҮБ-д мэдээлнэ. Уг үйл ажиллагаа ХСҮТ-ХҮБ, аймаг дүүргийн хавдрын тасгийн хавдар бүртгэгч хариуцан гүйцэтгэнэ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн-Шүүх эмнэлгийн хэлтэс

Задлан шинжилгээний явцад хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол оношлогдсон тохиолдлыг бүртгэнэ. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн-Шүүх эмнэлгийн хэлтэс нь ХСҮТ-ХҮБ-д удирдамжийн II бүлэгт хорт хавдрын шинэ тохиолдлыг мэдээлэх хугацаанд заагдсан хугацаанд улиралд нэг удаа мэдээлнэ. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн-Шүүх эмнэлгийн хэлтсийн хорт хавдрын мэдээг статистик мэдээллийн албаны статистикч эмч хариуцна.

Хавсралт-4:

## Хавдар бүртгэгчийн ажлын байрны тодорхойлолт.

### АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

**"А" Нийтлэг үндэслэл**

| Байгууллагын нэр | Нэгжийн нэр | |
|---|---|---|
| Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, төв | Хавдрын тасаг | |
| Ажлын байрны нэр | Ангилал | Зэрэглэл |
| Хорт хавдар бүртгэгч | ТҮЭМ | 4 |
| Шууд харъяалагдах ажлын байр (албан тушаал) | Шууд харъяалах албан тушаал | |
| Албаны дарга, Тасгийн эрхлэгч | | |
| Ажлын байрны зорилго | Харьяа орон нутгийн хорт хавдар өвчний анхан шатны маягтын бүртгэл болон эргэн дуудах тогтолцооны мэдээллийн санг улирал, жилээр хүлээн авч, шалган тулгаж, шифрлэх, нэгтгэх, тайлан мэдээ гаргах, эргэн мэдээлэх | |
| Ажлын байрны үндсэн чиг үүрэг | I. Холбогдох бүртгэлийн маягтыг үнэн зөв хөтлүүлэх, хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах<br>II. Мэдээ, мэдээллийг нэгтгэх, тайлагнах<br>III. Мэдээ, тайлан, мэдээлэлийн санг жилийн эцэст цэгцлэж архивлах, хадгалах<br>IV. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох<br>V. Мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх | |

***"Б" Ажлын байрны гол үйл ажиллагаа***

| *Ажлын байрны гол үйл ажиллагаа:* | *Хугацаа хуваарь:* |
|---|---|
| <u>Ажлын байрны I үндсэн зорилтын хүрээнд</u>:<br>- Хорт хавдрын болон эргэн дуудах тогтолцооны анхан шатны маягтын хангалт, бүртгэл мэдээллийн сангийн мэдээллийг шалгах, эргэн мэдээлэл хийх<br>- Анхан шатны маягтын үнэн зөв, бүрэн хөтөлсөн байдалд хяналт тавих,<br>- Зөрчил, алдаа гарсан тохиолдолд арилгуулах, арга зүйн зөвлөмжөөр хангах, | Тогтмол |
| <u>Ажлын байрны II үндсэн зорилтын хүрээнд</u>:<br>- Хорт хавдар болон эргэн дуудах тогтолцооны мэдээ, мэдээлэлийг сар, улирлаар авах, нэгтгэх,<br>- Тайланг батлагдсан маягт, аргачлалын дагуу хугацаанд нь гаргаж нэгтгэн холбогдох мэдээллийн албанд өгөх,<br>- Хорт хавдрын өвчлөл нас баралт болон эргэн дуудах тогтолцооны цахим мэдээний санг сар, улиралд цахим хэлбэрээр авах , нэгтгэх, шалгах, мэдээллийн давхардлыг арилгах,<br>- Мэргэжил арга зүйгээр хангах, , шаардлагатай арга хэмжээ авах талаар санал гаргах<br>- Эргэн мэдээлэх | |
| <u>Ажлын байрны III үндсэн зорилтын хүрээнд</u>:<br>- Хорт хавдар, эргэн дуудах тогтолцооны анхан шатны маягт, цахим мэдээний санд баяжилт хийх<br>- Хорт хавдар бүртгэх удирдамж болон эргэн дуудах тогтолцооны удирдамжид заасанаар мэдээллийг архивлах<br>- Өөрийн ажлын холбогдолтой судалгааны ажилд оролцох<br>- Төлөвлөх, бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшний удирдлагууд болон мэдээлэл хэрэглэгчдээс шаардсан мэдээ, | |

| | |
|---|---|
| мэдээллийг зөвшөөрлийн дагуу үнэн зөв, шуурхай гаргаж өгөх | |
| Ажлын байрны IV үндсэн зорилтын хүрээнд:<br>- Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, стандарт болон холбогдох зааврыг мөрдөж ажиллах | |
| Ажлын байрны V үндсэн зорилтын хүрээнд:<br>- Багц цагаа биелүүлэхийн тулд идэвхи санаачлага гаргах<br>- Байгууллагаас зохион байгуулж буй сургалтанд оролцох | |

**В.Тавигдах шаардлага**

| | | Үзүүлэлт | Зайлшгүй шаардлагатай | Шаардлагатай |
|---|---|---|---|---|
| 1.Ажлын байранд тавигдах шаардлага | 1.1 Ерөнхий шаардлагууд | Боловсрол | Бага эмч, статистикч бага эмч, сувилагч-Баклавр зэрэгтэй | - |
| | | Мэргэжил | Биостатистик чиглэлээр мэргэшсэн байж болно | - |
| | | Мэргэшил | Хавдрын бүртгэгч | - |
| | | Туршлага | | - |
| | | Нэмэлт ур чадвар | - Багаар ажиллах<br>- Харьцааны чадвар<br>- Компьютер ашиглах чавдартай<br>- Судалгааны арга зүйн талаар мэдлэгтэй<br>- Мэдээ , мэдээллийг тооцоолох, дүн шинжилгээ хийх ур чадвартай байх<br>- Мэргэжлийн ном товхимлыг гадаад хэл дээр ашиглах чадвартай | - |
| | 1.2.Тусгай шаардлага: | | - Ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллах<br>- Үйл ажиллагаагаа Авилгын эсрэг хуулийн хүрээнд явуулж, авилгаас ангид байх | |

**"Г". Хүчин зүйлс**

| | | |
|---|---|---|
| 1. Ажлын байрны харилцах субъект | | |
| 1.1.Байгууллагын дотор талд байгаа:<br>- Тасгийн эрхлэгч<br>- Тасгийн бусад ажилтнууд<br>- Бусад эмч, сувилагч | | 1.2. Байгууллагын гадна талд байгаа:<br>- ЗГХА-Эрүүл мэндийн газар<br>- ХСҮТ<br>- Анагаах ухааны боловсрол олгодог сургууль<br>- Өрх,сум, тосгоны эмнэлэг<br>- Төрийн болон төрийн бус байгууллага |
| 2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага | Хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, эмчийн ёс зүйн дүрэм, бусад хууль тогтоомж мөн ажлын байрны үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагаатай холбоотой асуудлыг төвийн захиргааны өмнө хариуцана. | |
| 3. Ажлын байрны нөөц хэрэгсэл | 3.1.Санхүүгийн: Цалин (ТҮЭМ- 5) | -Харилцаа хандлагын нэмэгдэл<br>-Хоол, унаа<br>-Холбогдох хууль тогтоомжын дагуу бусад нэмэгдэл (зэргийн нэмэгдэл г.м) |
| | 3.2.Материалын | - Эрүүл ахуйн шаардлага хангасан өрөө тавилга<br>- Ажлын хувцас (2 удаагийн)<br>- Хамгаалах хэрэгсэл<br>- Бичгийн хэрэгсэл<br>- Компьютер (интернетэд холбогдсон), принтер<br>- Телефон утас |
| | 3.3.Хүний | - |
| | 3.4.Бусад | Жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдах |

108

| | | |
|---|---|---|
| 4. | Ажлын байрны нөхцөл | Хэвийн |
| 5. | Орлон ба хавсарч ажиллах ажлын байрны нэр | |

**"Д". Баталгаажуулалт**

| Ажлын байрны тодорхойлолтыг баталсан | Ажлын байрны тодорхойлолтыг баталсан | Ажлын байрны тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн |
|---|---|---|
| Аймаг, дүүргийн ЭМН дарга<br><br>____________________<br>___оны __ сарын ___ -ны өдөр | Хавдрын тасгийн эрхлэгч<br>____________________<br>___оны __ сарын ___ -ны өдөр | Хавдар бүртгэгч<br><br>____________________<br>___оны __ сарын ___ -ны өдөр |